

Шударга сонгуулийн төлөө
иргэний нийгмийн хяналт сүлжээ

**СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ, САНАЛ ТООЛОХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖИГЛАЛТЫН ТАЙЛАН**

Ерөнхийлөгчийн сонгууль – 2017

Улаанбаатар хот

2017 он

**СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ, САНАЛ ТООЛОХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖИГЛАЛТЫН ТАЙЛАН**

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ – 2017

Энэхүү төслийг Нээлттэй Нийгэм Форум ТББ-ын
санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэв.

Төслийн тайланг боловсруулсан:

Б.Золзаяа, Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд ТББ-ын Захирал
Ц.Мандхайхатан, “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын Захирал
О.Гэрэлээ, Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд ТББ-ын Ерөнхий менежер
Т. Амарзаяа, “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын Менежер

Хянасан:

Д.Энхцэцэг, Шударга сонгуулийн төлөөх иргэний нийгмийн хяналт сүлжээний Зохицуулагч,
Нээлттэй Нийгэм Форумын менежер

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт

Өмнөх үг

Товч агуулга

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

- 1.1 Төслийн зорилго ба зорилтууд
- 1.2 Төслийн зохион байгуулалт
- 1.3 Төслийн үйл ажиллагаа

ХОЁР. АЖИГЛАЛТЫН АРГАЧЛАЛ

- 2.1 Ажиглалтын аргачлал

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- 3.1 Сонгуулийн үйл явцыг төрийн бус байгууллагаас ажиглагч ажиглах эрх зүйн зохицуулалт
- 3.2 Сонгуулийн санал авах, тоолох ажиллагааны эрх зүйн зохицуулалт
- 3.3 Техникийн тооллого хийх эрх зүйн зохицуулалт

ДӨРӨВ. АЖИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 4.1 Дотоодын байгууллагын ажиглагчийг бэлтгэх үйл ажиллагаа
- 4.2 Дотоодын байгууллагын ажиглагчаар бүртгүүлэх үйл явц

ТАВ. 6-Р САРЫН 26-НЫ САНАЛ ХУРААЛТЫН АЖИГЛАЛТЫН ДҮН

- 5.1 А – Санал авах ажиллагааны нээлт
 - Орчин
 - Автоматжуулсан системийн бэлэн байдал
 - Санал авах ажиллагааг эхлүүлэх
- 5.2 Б – Санал авах ажиллагаа
 - Санал авах ажиллагаа
 - Санал авах ажиллагааны зөрчил
 - Санал тоолох төхөөрөмжийн саатал, гэмтэл

5.3 В – Саналтоолох, санал хураалтын дүн гаргах

- Санал авах ажиллагаа хаалт
- Саналтоолох үйл ажиллагааны бэлтгэл
- Санал тоолох ажиллагаа
- Санал хураалтын дүн гаргах
- Санал тоолох ажиллагааны зөрчил
- Санал тоолох үе дэх төхөөрөмжийн саатал, гэмтэл
- Техникийн тооллого

ЗУРГАА. 7-Р САРЫН 7-НЫ САНАЛ ХУРААЛТЫН АЖИГЛАЛТЫН ДҮН

6.1 А – Санал авах ажиллагааны нээлт

- Орчин
- Автоматжуулсан системийн бэлэн байдал
- Санал авах ажиллагааг эхлүүлэх

6.2 Б – Санал авах ажиллагаа

- Санал авах ажиллагаа
- Санал авах ажиллагааны зөрчил
- Санал тоолох төхөөрөмжийн саатал, гэмтэл

6.3 В – Саналтоолох, санал хураалтын дүн гаргах

- Санал авах ажиллагаа хаалт
- Саналтоолох үйл ажиллагааны бэлтгэл
- Санал тоолох ажиллагаа
- Санал хураалтын дүн гаргах
- Санал тоолох ажиллагааны зөрчил
- Санал тоолох үе дэх төхөөрөмжийн саатал, гэмтэл
- Техникийн тооллого

6.4 Нийт ажиглалт хийх үед тулгарсан хүндрэл, бэрхшээл

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ХАВСРАЛТ:

1. Иргэний нийгмийн ажиглагчийн баримтлах ёс зүйн дүрэм
2. Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас бөглөх заавар, зөвлөмж
3. Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас: А – Санал авах ажиллагааны нээлт
4. Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас: Б – Санал авах ажиллагаа
5. Иргэний нийгмийн ажиглагчийн зөрчил, гомдлыг бүртгэх хуудас: Санал авах ажиллагааны Б шалгах хуудас
6. Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас: В – Санал тоолох, санал хураалтын дүн гаргах
7. Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явцын ерөнхий үнэлгээ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

СтХ- Сонгуулийн тухай хууль

СЕХ- Сонгуулийн Ерөнхий Хороо

ТББ-Төрийн бус Байгууллага

ХБИ- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

ННФ- Нээлттэй Нийгэм Форум

ӨТЗЭ- Өөрчлөлтийн төлөөх Залуу Эмэгтэйчүүд

БЗХ-Бодлогод залуусын хяналт

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үнэт зүйл болох хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлооход нэн тэргүүний шалгуур бол засгийн эрх мэдэл ард түмний хүсэл эрмэлзлээр баталгаажиж буй эсэх билээ. Үүний нэг илрэл, хэрэгжих арга зам нь бүх нийтийн, чөлөөт, шууд, ил тод, шударга сонгууль юм. Үүгээр зогсохгүй сонгууль нь тухайн улс оронд хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа иргэний улс төрийн эрх ямар түвшинд хангагдаж буйн илэрхийлэл, нийгмийн чухал институцууд үүргээ зохих ёсоор гүйцэтгэж буй эсэхийн шалгуур болдог билээ.

Сонгууль ил тод, шударга явагдах нөхцлийг хангах үүднээс, нарийвчилбал хууль, журамд заасны дагуу зохион байгуулагдаж байгаа эсэхэд иргэний нийгмийн байгууллагууд хөндлөнгийн хяналт тавих нь сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангах, болзошгүй зөрчил бүдлианаас сэргийлэх, улмаар сонгуульд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

Ийнхүү 2012 оны Улсын Их Хурлын сонгуулиас эхлэн төрийн бус байгууллагууд сонгуульд мониторинг хийх, хөндлөнгийн хяналт тавих эрхийг хуульд тусган баталгаажуулсан болно. Хуулийн хүрээнд бий болсон боломжид үндэслэн Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт сүлжээний зүгээс 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн 6-р сарын 26 болон 7-р сарын 7-ны өдрийн хоёр дах санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явцад хөндлөнгөөс хараат бус ажиглалт, хяналт хийсэн.

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн байгууллагууд нь 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явцад (1) Хэвлэл мэдээллийн мониторинг, (2) сонгуулийн автоматжуулсан системийн мониторинг, (3) сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг, (4) санал хураах, дүнг гаргах үйл явын ажиглалт гэсэн дөрвөн чиглэлээр мониторинг хийж гүйцэтгэв.

2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд санал тоолох үйл ажиллагааны автоматжуулалтын системийг үргэлжлүүлэн хэрэглэсэн. Өмнөх сонгуулиас ялгагдах онцлог гэвэл хоёр дахь санал хураалт явагдсан нь байлаа.

ТОВЧ АГУУЛГА

Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 14-р бүлэгт заасныг үндэслэн иргэний нийгмийн залуучуудын байгууллагууд хамтран хөндлөнгийн, бие даасан ажиглалт хийснээр сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангах, сонгуулийг шударга, зөрчил бүдлиангүй болгох, олон нийт, ялангуяа залуучуудын сонгуульд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд өөрсдийн хувь нэмрээ оруулсан чухал ач холбогдолтой төсөл хэрэгжсэн гэж үзэж байна.

Энэхүү ажиглалтыг удирдан зохион байгуулах ажлыг тус Сүлжээний гишүүн Өөрчлөлтийн төлөө Залуу эмэгтэйчүүд ТББ болон Бодлогод залуусын хяналт ТББ хамтран гүйцэтгэсэн ба ажиглалтын аргачлалыг 2004, 2008, 2009, 2012 болон 2016 оны сонгуульд ажиглалт хийсэн иргэний нийгмийн түршлага болон Азийн Чөлөөт Шударга Сонгуулийн Бүсийн сүлжээ мөн Филиппиний Чөлөөт Сонгуулийн Иргэдийн Үндэсний хөдөлгөөний ажиглалт хийх аргачлалд үндэслэн боловсруулсан юм.

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний 100 сайн дурын ажиглагч 2017 оны 6-р сарын 26 болон 7-р сарын 7-ны өдрийн хоёр дах санал хураалтаар Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явцад ажиглалт хийлээ. Эхний санал хураалтаар Улаанбаатар хотын сонгуулийн 6 дүүргийн 50 хэсгийн буюу нийт хэсгийн 12 хувь ба хоёр дах санал хураалтаар 20 хэсэг хамрагдсан бөгөөд сонгуулийн санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явц Сонгуулийн тухай хуулийн дагуу явагдаж буй эсэхэд ажиглалт, хяналт тавьлаа.

Түүнчлэн 6-р сарын 26-ны санал хураалтаар ажиглалт хийсэн нийт 50 хэсгээс 23 хэсэгт, 7-р сарын 7-ны санал хураалтаар 20 хэсгээс 11 хэсэгт тус, тус сугалааны зарчмаар сонгогдож техникийн тооллогод хамрагдсан болно.

Ажиглалт нь сонгуулийн санал хураах өдрийн 06:00 цагаас хэсэгт санал хураалтад бэлтгэснээс эхлэн санал хураах, санал тоолох үйл ажиллагаа, техникийн тооллого болон сонгуулийн эцсийн дүнг хэсгүүд хуралдаанаараа батлах үйл явцыг хамарсан. Төрлийн хувьд суурин ажиглалт хийсэн бөгөөд сонгуулийн баримт бичгийг тээвэрлэн дээд шатны сонгуулийн хороонд хүргэх ажиллагааг хянаагүй болно. Иргэний нийгмийн ажиглагчид нь төслийн багаас урьдчилан боловсруулсан сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагааг шалгах хуудас, санал тоолох үйл ажиллагааны үнэлгээний хуудас, санал тоолох үед гарсан өргөдөл, гомдол, хүсэлтийг бүртгэх хүснэгтийг зааврын дагуу бөглөж, цугласан мэдээллээ фото зураг авах, видео бичлэг хийх, баримт бичгийг хуулбарлан авах, урьдчилан бэлтгэсэн ажиглалтын болон үнэлгээний маягт бөглөх аргаар баримтжуулсан болно.

Төрийн бус байгууллагын 100 гаруй ажиглагчийн ирүүлсэн мэдээллийг нэгтгэн үзвэл 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураах, тоолох, дүнг гаргах болон техникийн тооллогын үйл явц хуулийн хүрээнд явагдсан ба сонгуулийн дүнд нөлөөлөхүйц ноцтой зөрчил гараагүй гэж дүгнэж байна. Ажиглалт хийсэн хэсэгт зохион байгуулалтын болон тохиолдлын чанартай жижиг зөрчлүүд гарсан ч энэ нь санал тооллогын дүнд сөрөг нөлөө үзүүлээгүй байна.

Санал авах байр, орчин:

Санал авах байрны орчин, дотоод зохион байгуулалт, аюулгүй байдал, сонгогчийн бүртгэл дэх зургийг нийтэд үзүүлэх дэлгэцийг бэлдсэн зэрэг сонгуулийн хэсгүүдийн зохион байгуулалт сайн байсан ч дараах дутагдлууд ажиглагдсан. Үүнд:

- Хэсгийн 25 хувьд санал бэлтгэх бүхээгүүдийг хооронд нь хэт ойр зайтай байрлуулснаас үүдэлтэй сонгогч саналаа нууцаар бэлтгэх боломж бага, саналын нууцлал алдагдах магадлалтай.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэсгийн 32 хувьд нь байршуулаагүй.
- Тэргэнцэртэй иргэдийг зорчих налуу замыг хэсгийн 68 хувьд нь урьдчилан бэлтгээгүй.
- ТББ-ын ажиглагчдыг санал авах үйл явцыг саадгүй ажиглах боломжтой орчинг 10 хувь нь бий болгоогүй байсан.
- Тог тасраагүй орчин сайн байсан.
- Нэг хэсэгт машинруу камер чиглэсэн байсан.

Санал авах ажиллагааны нээлт:

- Санал авах ажиллагааны нээлт хэсгүүдэд хуульд заасан 07:00 цагт нээгдсэн байна.
- Сонгуулийн тухай 89.1-д зааснаар санал авах ажиллагааны нээлтэнд бэлтгэх үйл явцад хэсэгны гишүүд болон ажиглагчдын оролцуулахаас гадна сонгогчийн төлөөллийг байлгах ёстой атал хэсгийн 44 хувьд сонгогчийн төлөөллийг байлцуулаагүй байна.
- Санал авах ажиллагааны нээлтэнд бэлтгэх үйл явцад ажиглагчдад хуулиар олгогдсон эрхийн хүрээн дэх мэдээллийг авах боломжоор хангаагүй тохиолдлууд байна. Жишээлбэл, Эхлэлийн тэг тайлан буюу лог тайланг 14хувьд нь хэвлэн өгөөгүй бөгөөд зөвхөн намын ажиглагчдад өгнө, сонгуулийн өмнөх өдөр ирж гарын үсэг зурах шаардлагатай байсан зэрэг шалтгаанаар татгалзсан байна. Мөн саналын хуудсын индексийг авах, зөөврийн хайрцагаар авсан саналын холбоотой мэдээллийг олж авах ажиглагчдад хүндрэл учирчээ.

Санал авах үйл явц:

Санал тоолох үйл явцыг төрийн бус байгууллагын 50 хэсэгт биечлэн ажигласан бөгөөд ажиглагчдын 86 хувьд санал тоолох үйл ажиллагааг бүхэлд нь ажиглаж болохуйц байжээ. Ажиглагчдын мэдээллээс үзвэл санал тоолох үйл явцад ноцтой зөрчил дутагдал гараагүй бөгөөд нээлттэй, ил тод явагдсан байна.

Санал авах ажиллагаа 49 хэсэгт завсарлаагүй явагдсан байна. Ажиглалт явагдсан хэсгүүдийн санал хураах үйл явцыг ерөнхийд нь дүгнэхэд хуульд заасан журмын дагуу хэвийн явагдсан. Сонгуулийн хэсгүүд хуульд заасан цагт санал авах ажиллагааг эхлүүлсэн бөгөөд зарим газарт санал авах төхөөрөмжийг угсрах, ажиллуулах зэрэгт их цаг зарцуулсны улмаас хожимдож эхлүүлсэн тохиолдол гарсан.

- Сонгуульд санал өгөхтэй холбоотой мэдээлэл сонгогчдод дутмаг байснаас үүдсэн зарим хүндрэл ажиглагдсан. Жишээлбэл, Сонгогч саналын хуудсанд саналаа хэрхэн тэмдэглэх талаарх мэдээлэл дутмагаас болж 2000 гаруй саналын хуудас хүчингүй болсон, 51 хувьд нь саналын хуудсыг төхөөрөмжид уншуулахад хүндрэлтэй байсан байна. Үүний улмаас сонгогчийн саналын нууцлал алдагдах, бусад хүмүүст харагдах тохиолдлууд гарч болзошгүй байжээ.

- Мөн сонгогч хэсгээ мэдэхгүй андуурсан 95 болон түүнээс дээш тохиолдол гарчээ. Түүнчлэн хэсгүүдэд Сонгуулийн тухай хуульд зааснаар хоосон саналын хуудас уншуулах буюу “Дөрөв дэх сонголт” хийх гэж буй иргэнийг заавал саналын хуудсыг бөглөхийг шаардах тохиолдлууд байсан ба сонгогч нэгээс олон нэр дугуйлах тохиолдлууд гарчээ.

Нэрсийн жагсаалттай холбоотой гарсан зөрчлийн хувьд оршин суух харьяалал мөн боловч сонгогчдын нэрсийн жагсаалтанд байхгүй 18 тохиолдол, хаяг дээр байхгүй хүнийг нэрсийн жагсаалтанд бүртгэгдсэн гэсэн 58 тохиолдол бүртгэгджээ.

Сонгогчийн хувьд бэхэн тэмдэглэгээг эсэргүүцсэн 45, өндөр настны өмнөөс хамт яваа хүн бөглөсөн 28 тохиолдол (итгэмжлэлийг шалгаагүй), саналын хуудасны зураг авах, сонгогчид хоорондоо ярилцах гэсэн зөрчлүүдийг ажиглагдсан.

Ажиглалт явуулсан хэсгүүдийн хувьд 50 хувьд нь намын ажиглагчид, 60хувьд нь сонгогч гомдол гаргасан гэсэн боловч 50 хувьд нь хэсгийн ажилтнуудын санал гомдлыг хүлээн авч, тэмдэглэл хөтлөөгүй гэж тэмдэглэгдсэн байна.

Санал тоолох төхөөрөмж болон хурууны хээ таних төхөөрөмжийн ажиллагаа:

Ажиглагчдаас ирүүлсэн мэдээллээс үзвэл хурууны хээ таних төхөөрөмжийн ажиллагаатй холбоотой хүндрэлүүд тэмдэглэгдээгүй байна. Хэсгүүдийн 91 хувь нь сонгогч тус бүрийн хурууны хээг уншуулан таниулж, иргэний үнэмлэхний мэдээлэлтэй тулгаж нягталж байсан гэсэн бөгөөд зарим хэсгүүд хурууны хээ уншиж буй тохиолдолд, иргэний үнэмлэх

шаардаагүй байна. Мөн долоовор хурууны хээ таниагүй тохиолдолд хэсгүүдийн 90 хувь нь бусад хуруунуудыг уншуулж байсан байна.

Мөн хэсгүүдийн 78,9 хувьд нь санал тоолох ажиллагааны үед санал тоолох төхөөрөмж эвдэрч, гацаагүй гэсэн. Энэ нь иргэд төхөөрөмжинд саналын хуудас уншуулахдаа хавтастай нь хийсний улмаас төхөөрөмжийг гацаах, гэмтээх тохиолдол гарч байсан байна. Үүний улмаас төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг зас дээд тал 60 минут хүртэл хугацаа зарцуулах, нэг төхөөрөмжтэй нэг хэсэг санал авах ажиллагаа завсарлахад хүрсэн байна. Журмын дагуу төхөөрөмжийн эвдрэл гэмтэл бүрт тэмдэглэл хөтлөх шаардлагатай боловч нийт хэсгүүдийн 50 хувьд энэ тэмдэглэл хөтлөөгүй байна.

Санал тоолох төхөөрөмжинд 59 хувьд нь эвдрэл, гэмтэл гараагүй гэсэн бөгөөд гэмтэл гарсан тохиолдлуудад мэдээлийн даамал тухай бүр нь засварлаж, шаардлагатай тохиолдолд Сонгуулийн ерөнхий хорооны засварлах баг ирж тухай бүр нь асуудлыг шийдвэрлэжээ.

Санал тоолох үйл явц:

Санал тоолох үйл явц хуулийн дагуу 22 цагт эхэлсэн байна. Хэсгүүдэд санал тоолох ажиллагаа завсарлалгүй шууд явагдсан гэсэн бөгөөд зарим хороодод санал тоолж хэвлэх үед цаас нь дууссан, зааварчилгаа хүлээсэн, СЕХ-оос техникийн тооллого явагдах эсэхийг хүлээсэн зэрэг шалтгаантай байсан байна.

Ийнхүү нийт хэсэгдын 95 хувь нь саналын хуудасны дүнг ажиглагчдад хэвлэж өгсөн ба 95хувь нь дүнг уншиж сонсон, 92хувь нь нэн даруй буюу дунджаар 10-30 минутын дотор мэдээлжээ. Мөн 98 хувь нь саналын хуудасны зурган файлыг ажиглагчдад CD дээр хуулж өгсөн бөгөөд техникийн мэдлэг болон бэлтгэл хангалтгүй, зурган файлыг хуулж авах хүсэлтээ бичгээр гаргах, заавал DVD авчрахыг шаардсанаас зарим хэсэг ажиглагчид мэдээллийг авч чадсангүй.

Сонгуулийн хэсгийн гишүүдийн мэдээлэл дутмагаас хуулиар заасан тэмдэглэлүүдийг цаг тухайд нь хөтлөөгүй болон санал авахад зарцуулаагүй үлдсэн саналын хуудасны хуудсыг баруун дээд буланг хайчлалгүй битүүмжилсэн тохиолдол байна.

Техникийн тооллого:

Төрийн бус байгууллагын ажиглалтыг зохион байгуулах багийн төлөөлөл ажиглалт явуулсан нийт 6 дүүргийн техникийн тооллого явагдах хэсгүүдийг сугалах ажиллагаанд оролцох хүсэлт гарган, биеэр оролцож хөндлөгийн ажиглалт хийсэн. Ийнхүү бидний ажиглалт хийсэн 50 хэсгээс 23 хэсэг сугалаагаар сонгогдсон. Ажиглагчдын мэдээллээс үзэхэд техникийн тооллого явагдах үйл явц ажиглагчдад нээлттэй явагдсан ба СЕХ-оос

баталсан журмын дагуу явагджээ. Техник тооллого дунджаар 1 цаг 30 минутын дараа эхэлсэн ба дунджаар 3-8 цаг үргэлжилсэн.

Техникийн тооллого хийгдсэн хэсгүүдэд санал тоолох машины дүн болон гараар хянаж тоолсон дүнгийн зөрүү гараагүй байна. Нэг хэсэг дээр нь саналын хуудас болон санал авах машины санал зөрөх тохиолдол гарсан байна. Тодруулбал саналын зөрүү гарах тохиолдол, шалтгаан нь нэр дэвшигчийн өмнөх дугаарыг тойруулан тэмдэглэсэн байдал, мөн хэсгүүдийн ажилчид олон цаг ажилласны улмаас алдаж тоолох тохиолдлууд ажиглагдсан байна.

Ажиглалт хийхэд учирсан хүндрэл бэрхшээл:

Хуулийн дагуу төрийн бус байгууллага сонгуулийг ажиглах үйл явцыг Сонгуулийн Ерөнхий хороо дэмжиж ажилласан боловч дүүргийн болон хэсгийн сонгуулийн хорооны ажилтнууд иргэний нийгмийн ажиглагчдыг бүртгэж, үнэмлэх олгохоос татгалзах зэрэг хүндрэл учирч байсан.

Мөн ажиглагчдад мэдээлэх шаардлагатай зарим мэдээллийг дутуу хэлэх, орхих, санал тоолох төхөөрөмжийн гэрчилгээ, серийн дугаарыг тэмдэглэж, мэдээлэл авах, саналын хуудасны зурган файлыг хуулбарлан авах боломжоор бүх хэсгүүд хангаж чадаагүй.

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн зорилго ба зорилтууд

ЗОРИЛГО

Ажиглалтын зорилго нь 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураах, тоолох, дүн гаргах үйл явц нь хууль болон тогтоосон журмын дагуу явагдаж буй эсэхийг зохих аргачлалын дагуу хянаж, хяналт тавих, уг үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, улмаар болзошгүй зөрчлөөс сэргийлэх зорилготой юм.

ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилгын хүрээнд:

- Сонгуулийн санал авах, санал тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд хөндлөнгийн ажиглалт хийж, хяналт тавих замаар уг үйл ажиллагаа хуульд заасан журам, нөхцлийн дагуу явагдаж буй эсэх, нээлттэй, ил тод байх хуулийн шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоох, зөрчлийг баримтжуулах;
- Сонгуулийн үйл явцад хяналт тавих иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, үүнд залуучуудыг татан оролцуулах замаар иргэний боловсролд нь хувь нэмэр болох ;
- Мөн ажиглалтын дүнд үндэслэн сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход нөлөөлөх явдал юм.

Дээрх зорилтод хүрэхэд чиглэсэн дараахь үйл ажиллагааг төслийн хүрээнд зохион байгуулж гүйцэтгэлээ:

- Сүлжээний болон Азийн сонгуульд хяналт тавьдаг иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээний аргачлал, туршлагад үндэслэн ажиглалтын аргачлал сайжруулан боловсруулах,
- Сонгуулийн насанд хүрсэн, нам бус, төрийн албан хаагч бус (ойролцоогоор 100 ажиглагч) иргэний нийгмийн болон залуусын байгууллагуудаас тодорхой шалгууртайгаар сонгон авч ажиглагчаар бүртгэн, холбогдох хууль, журам болон ажиллах ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалт зохион байгуулах,
- Ажиглагчдыг СЕХ-ноос баталсан зохих журмын дагуу бүртгүүлэх ажлыг нэгдсэн удирдлагатайгаар зохион байгуулах,

- Улаанбаатар хотын 6 дүүргийн 50 хэсгийг түүврийн аргаар сонгож сонгуулийн санал хураах, санал тоолох, дүн гаргах болон хяналтын тооллогын үйл ажиллагааг ажиглах, санал тоолох үйл явцтай холбоотой мэдээлэл цуглуулах,
- Санал тоолох үйл ажиллагааг ажиглаж ажигласан дүнгээ олон нийтэд хүргэж тайлагнах,
- Ажиглалтын үр дүн, санал зөвлөмж бүхий тайлан боловсруулан гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх.

1.2 Төслийн зохион байгуулалт

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн байгууллагуудын төлөөлөл болон бусад сайн дурын ажилтнуудаас сонгуулийн ажиглагчдын баг бүрдсэн бөгөөд төслийн удирдагчаар Өөрчлөлтийн төлөөх Залуу эмэгтэйчүүд ТББ болон Бодлогод Залуусын Хяналт ТББ хамтран ажиллалаа.

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний 100 сайн дурын ажиглагчид сонгуулийн хуулийн агуулга, хэрэгжилтийн явцад тулгардаг бэрхшээл болон автоматжуулсан сонгуулийн зарчим, үйл явц, эрсдэл, давуу болон сөрөг талууд, сонгуулийн өдрийн ажиглалтын шалгах хуудсыг хэрхэн боловсруулах, ажиглалтын тайлан боловсруулж бичих аргачлал, сонгуулийн ажиглагчийн эрх, үүрэг, хариуцлага, дагаж мөрдөх ёс зүйн зарчмын талаар ойлголт өгөх зорилготой сургалтад хамрагдсан. Энэхүү сургалтыг 2016 оны сонгуулийн ажиглагчдад зориулсан сургалтын арга барилыг шинэчлэн явуулсан.

Төслийн багийн зүгээс сонгуулийг ажиглахдаа аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг төлөөлөхгүй, төвийг сахиж, сонгуулийн хууль тогтоомжийн хүрээнд ажиллах агуулга бүхий Иргэний нийгмийн ажиглагчийн ёс зүйн гэрээг ажиглагч тус бүртэй байгуулж, хяналт тавьж ажилласан.

Төслийн үйл ажиллагаа нь дараах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжих болно.

Мөн сүлжээний гишүүн байгууллагуудын төлөөлөл болон бусад иргэний нийгмийн байгууллага, их сургуулийн оюутнууд зэргээс ажиглагчдын баг бүрдсэн. Нийт 100 ажиглагч 5 багт хуваагдан, тэднийг удирдан зохион байгуулсан баг ажилласан байна.

1.3. Төслийн үйл ажиллагаа

Төслийн зорилго, зорилтод чиглэсэн дараах үйл ажиллагааг төслийн хүрээнд зохион байгуулав.

- Сүлжээний болон Азийн сонгуульд хяналт тавьдаг иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээний аргачлал, туршлагад үндэслэн ажиглалтын аргачлал сайжруулан боловсруулах,
- Сонгуулийн насанд хүрсэн, нам бус, төрийн албан хаагч бус (100 ажиглагч) иргэний нийгмийн болон залуусын байгууллагуудаас тодорхой шалгууртайгаар сонгон авч ажиглагчаар бүртгэн, холбогдох хууль, журам болон ажиллах ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалт зохион байгуулах,
- Ажиглагчдыг СЕХ-ноос баталсан зохих журмын дагуу бүртгүүлэх ажлыг нэгдсэн удирдлагатайгаар зохион байгуулах,
- Улаанбаатар хотын 6 дүүргийн 50 хэсэгийг түүврийн аргаар сонгож сонгуулийн санал хураах, санал тоолох, дүн гаргах болон хяналтын тооллогын үйл ажиллагааг ажиглах, санал тоолох үйл явцтай холбоотой мэдээлэл цуглуулах,
- Санал тоолох үйл ажиллагааг ажиглаж ажигласан дүнгээ олон нийтэд хүргэж тайлагнах,
- Ажиглалтын үр дүн, санал зөвлөмж бүхий тайлан боловсруулан гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх.
- 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын үр дүнгийн улмаас зохион байгуулагдсантай хоёр дах санал хураалтын ажиглалтын үйл ажиллагааг түргэвчилсэн байдлаар зохион байгуулсан.

Хэвлэлийн хурал:

2017 оны 6-р сарын 28-ны өдөр. Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд зохион байгуулсан хэвлэлийн бага хурлаар сонгуулийн иргэний нийгмийн ажиглалтын үр дүнг танилцуулж, 40 орчим хэвлэл мэдээллийн төлөөлөгчид, олон улсын судлаачид цугларсан бөгөөд Фэйсбүүк хуудсаар дамжуулан лайв бичлэг хийж баримтжуулж, түгээсэн болно.

Хэвлэлийн хуудсыг хавсаргав.

ХОЁР. АЖИГЛАЛТЫН АРГАЧЛАЛ

2.1. Ажиглалтын аргачлал

Сонгуулийн үйл явцын ажиглалт нь сонгуулийн санал хураах өдрийн 06:00 цагаас санал авах хэсэгд санал авахад бэлтгэснээс эхлэн санал авах, санал тоолох үйл ажиллагаа болон санал хураалтын дүнг хэсэгд хуралдан батлах үйл явцыг хамарсан. Иргэний нийгмийн ажиглагчид нь төслийн багаас урьдчилан боловсруулсан сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагааг шалгах хуудас, санал тоолох үйл ажиллагааны үнэлгээний хуудас, санал тоолох үед гарсан өргөдөл, гомдол, хүсэлтийг бүртгэх хүснэгтийг зааврын дагуу бөглөж, цугласан мэдээллээ фото зураг авах, видео бичлэг хийх, баримт бичгийг хуулбарлан авах, урьдчилан бэлтгэсэн ажиглалтын болон үнэлгээний маягт бөглөх аргаар баримтжуулсан.

Төрлийн хувьд суурин ажиглалт хийсэн бөгөөд сонгуулийн баримт бичгийг тээвэрлэн дээд шатны сонгуулийн хороонд хүргэх ажлыг хамраагүй болно.

Ийнхүү сонгуулийн үйл явцыг бүхэлд нь ажиглаж, дүн шинжилгээ хийн, санал дүгнэлтийг боловсруулахад дараах аргуудыг ашиглав.

- Ажиглалт
- Санал асуулга
- Ярилцлага
- Баримт бичигт дүн шинжилгээ хийх

Ажиглалт:

Ажиглалтын аргачлалыг Филиппиний Чөлөөт сонгуулийн төлөө иргэдийн үндэсний хөдөлгөөн (NAMFREL/НАМФРЕЛ), Азийн чөлөөт сонгуулийн төлөө бүсийн сүлжээний (ANFREL/АНФРЕЛ) болон Европын байгууллагуудын аргазүй, туршлагад үндэслэн боловсруулсан 2012 оны ажиглалтын хуудсыг 2016 оны сонгуулийн хуульд зохицуулан шинэчлэн боловсруулсан хувилбарыг 2017 онд Ерөнхийлөгчийн сонгуульд зориулан шинэчлэн, сайжруулсан болно. Дотоодын холбогдох хууль тогтоомж, журмыг түшиглэн ажиглалт хийх шалгах хуудсыг дараах 4 бүлэг асуудлаар тус бүр нарийвчлан боловсруулсны дотор:

1. “А - Санал авах ажиллагааны нээлт,”
2. “Б – Санал авах ажиллагаа,”
3. “В – Санал тоолох, санал хураалтын дүн гаргах” болон

4. “Иргэний нийгмийн ажиглагчийн зөрчил, гомдлыг бүртгэх хуудас” тус тус багтсан. Эдгээр шалгах хуудас нэг талаас сонгуулийн санал хураалтын үйл явцыг ажиглах хөтөч, нөгөө талаас баримтжуулах арга хэрэгсэл болсон юм.

Асуулга:

Ажиглалтад хамрагдсан хэсэгд хяналт тавьсан улс төрийн нам, эвслийн ажиглагчид сонгуулийн санал авах ажиллагаа, санал тоолох төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалт, санал тоолох ажиллагааны явцыг хэрхэн үнэлж буйг асуулгын аргаар судалсан.

Ярилцлага:

Хэсгүүд дээр манай ажиглагчид 6-16 цагийн хооронд, 16 цагаас сонгуулийн дүн гаргах хүртэл хугацаанд ээлжлэн, зарим ажиглагчид бүтэн өдрөөр хяналт тавьсан бөгөөд сонгуулийн үйл явцыг талаарх мэдээллийг шуурхай хүлээн авч, баримтжуулах зорилгоор 6-16 цагийн хооронд ажилласан нэгдүгээр ээлжийн ажиглагчидтай утсаар болон биечлэн ярилцаж дараах асуудлуудаар мэдээлэл авсан. Мөн ажиглагчид фэйсбүүкээр цаг үеийн мэдээллийг зурагтайгаар тухай бүрт нь мэдээлж байсан.

Үүнд “Санал хураах үйл явц цагтаа эхэлсэн үү. Зохих дарааллын дагуу явагдсан үү,” “Сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой зөрчил гарч байна үү?” “Санал тоолох төхөөрөмжинд саатал, гэмтэл гарч байна үү?” “Санал авах ажиллагааны явцад сонгогч болон ажиглагч нараас гомдол гарч байна үү?” “Ажиглагт хийхэд ямар нэг хүндрэл бэрхшээл учирч байна уу. Тийм бол ямар?”

Мөн сонгуулийн өдрийн дараа тухайн хэсэгнд ноцтой зөрчил гарсан болон тодруулах шаардлага гарсан ажиглагчидтай биечлэн уулзаж холбогдох мэдээллийг цаг алдалгүй баримтжуулсан болно.

Баримт бичигт дүн шинжилгээ хийх:

Сонгуулийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, мөн сонгуулийн хороодоос дотоодын байгууллагын ажиглалт болон санал авах, санал тоолох үйл явцтай холбогдуулан гаргасан шийдвэр эрх зүйн баримт бичгүүд, хэсэгдын тогтоол, санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн “эхлэлийн лог” хуудас, дүнгийн тайлан болон улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн бөглөсөн сонгуулийн ерөнхий үнэлгээ зэрэг баримт бичгийг нэгтгэн судалсан.

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН

3.1 Ажиглалт хийх эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн ажиглалт нь 2015 оны Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль болон СЕХ-оос баталсан “Төрийн бус байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах журам,” “Сонгуулийн автоматжуулсан системийн мэдээллийн сангийн мэдээлэл, түүнтэй холбогдох бусад мэдээллийг нууцлах, нууцалсан мэдээлэлтэй харьцах журам,” “Техникийн тооллого хийх тухай журам” зэрэг хууль тогтоомжийн хүрээнд явагдсан.

Мөн Сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр бүлэгт ТББ болон улс төрийн намаас ажиглагчийг томилон, сонгуулийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх үйл явц, ажиглагчийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхой заасан. Түүнчлэн тус хуулийн 5-р зүйлд төрийн бус байгууллага “ажиглалт хийх” эрхтэй гэж зарчим болгон тусгаж, холбогдох журмуудаар ажиглалтын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулахыг зохицуулсан байна.

Ийнхүү СЕХ-ноос баталсан “Төрийн бус байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах журам”-д заасны дагуу СЕХ-нд Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүд хандаж, тус байгууллагын 2017 оны 5-р сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор бүртгэгдэж, ажиглалт хийх эрхтэй болсон.

Тус хуулийн 107.2- т “төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий **төрийн бус байгууллага нь нэг хэсэгт нэг ажиглагч томилон ажиллуулах эрхтэй,** ” 108.3-т “Ажиглагчийн эрх нь ажиглагчийн үнэмлэх авснаар эхэлж, сонгуулийн албан ёсны дүн гарснаар дуусгавар болно” гэсэн. Түүнчлэн ТББ нь сонгууль болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороодод 107.8-д хуульд заасан баримт бичгийг хүргүүлэх үүрэгтэй юм.

2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай болж өнгөрсөн бөгөөд сонгууль тус бүрд хуулийн дээрх шаардлагын дагуу ажиглагчдыг бүртгүүлж, үнэмлэх авсан.

Төрийн бус байгууллагын ажиглагчийн эрх, үүргийг хуулиар тусгайлан заасан байна. Тухайлбал, сонгуулийн өдрийн санал авах ажиллагааны үйл явцыг бүхэлд нь буюу нээлтийн хэсгээс хаалт хүртэл, техникийн тооллогод болох тохиолдолд ажиглалт хийх эрхтэй гэсэн. Мөн ажиглагч нь **зөвхөн хөндлөнгөөс ажиглана** гэж тодорхой тусгажээ. Түүнчлэн, хуулийн 108.2 дугаарт нийт 12 төрлийн эрх эдлэх болохыг тодорхой тусгасан ба эдгээр эрх нь мэдээлэл авах, түгээх, санал гомдол гаргах зэрэг боломжийг бүрдүүлсэн юм.

3.2. Сонгуулийн санал авах, тоолох ажиллагааны эрх зүйн зохицуулалт

Санал авах ажиллагааг СтХ-ийн 11 дүгээр бүлгээр зохицуулсан. Санал авах ажиллагааг 07:00 цагт эхлүүлэхийн өмнө санал авах байрны бүрэлдэхүүн СтХ-ийн 89 дүгээр зүйлд заасан ажиллагааг дарааллын дагуу гүйцэтгэж тэмдэглэл үйлдэнэ. Тухайлбал,

- Тухайн санал авах байрны сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, үүнээс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн сонгогчдын тоог мэдээлэх;
- Санал авах байрны байршлаас хамааран тусгайлан тогтоосон саналын хуудасны индекс, дугаарыг мэдээлэх
- Хүлээн авсан, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авахад зарцуулсан, саналаа буруу тэмдэглэсэн үндэслэлээр дахин олгосон зэрэг, алдагдаж, үрэгдсэн, устгагдсан болон үлдсэн саналын хуудасны тоог мэдээлэх
- Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаас бусад санал авах бүх хайрцгийг нээж харуулан хоосон эсэхийг бататгаад, санал тоолох төхөөрөмжийг битүүмжлэн, лацдаж, санал авахад бэлэн болгох;
- Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн сонгогчдын саналыг санал тоолох төхөөрөмжид хийн, улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар бүртгэлийн хуудас гаргуулна.

Мөн СтХ-ийн 92 дугаар зүйлд зааснаар сонгогч санал өгөхөд үндсэн 3 алхамтай байна:

1-р алхам. Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах ажиллагаа буюу хурууны хээг уншуулж, саналын хуудсыг авснаа баталгаажуулж, гарын үсэг зурна. Энэ сонгуулиар иргэний үнэмлэхийг нэрийн жагсаалттай тулгах шаардлагыг тавиагүй болно.

2-р алхам. Санал тэмдэглэх буюу санал бэлтгэх бүхээгт саналаа өгнө. Ингэхдээ санал өгөх зааварчилгаатай танилцаж болох бөгөөд зөвхөн нэг нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх юм. Харин сонгогч нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн тухайн сонгогчийг санал өгсөн сонгогчдын тоонд оруулан тооцно.

3-р алхам. Саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжинд уншуулах буюу төхөөрөмжийн дэлгэцэнд “САНАЛЫН ХУУДАС УНШИХАД БЭЛЭН” гэсэн мэдээлэл гарч ирсний дараа аль ч талаар нь харуулан саналын хуудсыг хийнэ. Саналын хуудас хийсний дараа “САНАЛЫН ХУУДАС АМЖИЛТТАЙ УНШИГДЛАА” гэсэн мэдээлэл гарч ирснээр санал тоологдоно.

Ийнхүү сонгогчид 22 цаг хүртэл санал авч дуусмагц санал хураалтын дүн гаргах, нэгтгэх үйл ажиллагааг СтХ-иар арван хоёрдугаар бүлэгт зохицуулсан. Хуулийн зохицуулалтаас үзэхэд санал тоолох ажиллагааны бэлтгэл, санал тоолох ажиллагаа, саналын хуудасны тоог нягтлах, санал хураалтын дүн, баримт бичгийг хүргүүлэх гэсэн дараалалтай байхаар зохицуулж, ажиглагчийг оролцуулан ил тод, нээлттэй явуулна гэсэн байна.

Санал тоолох ажиллагаа нь үндсэн 3 алхмаас бүрдэнэ:

1-р алхам. Санал тоолох ажиллагааны бэлтгэл буюу саналаа өгсөн нийт сонгогчдын тоог олгосон саналын хуудастай тохирч буй эсэхийг нягталж, зарцуулаагүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудасны тоог тулган хүчингүй болгоно.

2-р алхам. Санал тоолох ажиллагаа буюу санал тоолох төхөөрөмжийг ажиллуулж, саналыг тоолж, “санал хураалтын дүнгийн хуудас”-ыг хэвлэж, үр дүнгийн мэдээллийг Сонгуулийн Ерөнхий Хороонд нэн даруй дамжуулна. Ингэхдээ санал тоолж эхэлснээс хойш санал хураалтын дүн гарч дуусах хүртэл хэсэгны үйл ажиллагаа завсарлаж болохгүй гэж хуульчилсан.

3-р алхам: Санал хураалтын дүн, баримт бичгийг хүргүүлэх буюу санал авах байр дараах баримт бичгийг дүүргийн сонгуулийн хороонд хүргэнэ. Үүнд:

- (a) Ахлах зохион байгуулагчийн гарын үсэг зурсан санал хураалтын дүнгийн хуудас
- (b) Санал тоолох ажиллагааны бэлтгэл шатанд битүүмжилж бэлтгэсэн саналын хуудаснууд.

Эдгээр баримт бичгийг дүүргийн сонгуулийн хороонд хүргэх бэлтгэл ажил хангагдсанаар ажиглагч хэсэгны байрыг орхин явах боломжтой болох юм.

3.3 Техникийн тооллого хийх эрх зүйн зохицуулалт

Санал хураалтын дүнг төв серверт дамжуулсны дараа СтХ-д зааснаар техникийн тооллого явагдаж болно. Техникийн тооллого гэдэг нь санал тоолох төхөөрөмжийн дүн, уншигдсан саналын хуудасны дүнтэй таарч буй эсэхийг гар ажиллагаагаар тоолж, баримтжуулах ажиллагаа юм. Хуулийн 97.13-т “Санал хураалт дууссаны дараа сум, дүүргийн сонгуулийн хороо санамсаргүй сонголт /сугалах/-ын аргаар харьяа хэсэгнээс **50 хүртэл хувийг сонгож 24 цагийн дотор техникийн тооллого хийнэ.** Техникийн тооллогод сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн болон сонгогчдын төлөөллийг оролцуулна” гэж заасан.

Мөн хуулийн 97.14-т “Техникийн тооллого хийх журмыг сонгуулийн төв байгууллага батална” гэсний дагуу СЕХ-ноос 2016 оны 6-р сарын 21-ний 172 дугаар тогтоолоор “Техникийн тооллого хийх журам”-ыг баталсан.

Тус журмын 1.3-т “Техникийн тооллого хийгдэх санал авах байрыг сонгох болон техникийн тооллого хийх ажиллагаанд сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн ажиглагчдыг оролцуулна. Гадаадын ажиглагчид, **сонгогчид**, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг ажиглагчаар оролцуулж болно” гэсэн. Энэ нь үйл явцад зөвхөн гадаадын ажиглагч байна гэсэн нь СтХ-ийн 5 дугаар зүйлд заасан ил тод байх, ТББ-ын ажиглагч нь хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих эрхтэй гэсэн заалтыг явцууруулсан байна. Иймд энэхүү үйл явцад ТББ-ын ажиглагч нь “сонгогч”-ийн төлөөлөл гэсэн утгаар оролцох хүсэлтийг дүүргийн сонгуулийн хороонд тавихаас өөр аргагүй болсон.

Мөн журмын 2.1-д зааснаар техникийн тооллого хийгдэх санал авах байрыг сонгохдоо сум, дүүргийн сонгуулийн хороо сугалаа явуулахаар зохицуулсан. Ийнхүү техникийн тооллого хийх хэсэгд тодорхой болсны дараа тухайн хэсэгд дараах зохион байгуулалтаар техникийн тооллого явуулах бөгөөд ил тод, нээлттэй зохион байгуулна. Үүнд:

1. Эхлэхийн өмнөх бэлтгэл ажил: Санал авах ажиллагаанд зориулсан бүх үзгийг хураан авч битүүмжлэх, саналын хайрцагны лацын бүрэн бүтэн байдлыг шалгуулсны үндсэн дээр хөндөх, саналын хуудсыг тус бүр 25 ширхэгээр нь тоолж багцлан, багц тус бүр болон саналын хуудсыг дугаарлах, саналын хуудасны тоо нь сонгогчийн тоотой тохирч буй эсэхийг мэдээлнэ.
2. Тооллого хийх: Багцалсан саналын хуудсыг дугаарласан дарааллын дагуу нэг бүрээр нь уншиж танилцуулах ба ажиглагчдад ил тод харуулна.
3. Дүнг нэгтгэх: Нэр дэвшигчид өгсөн саналыг тоолохдоо саналын хуудас тус бүрээр тоолж, багц тус бүрээр дүнг нэгтгэн гарган дүнгийн нэгтгэлд бүртгэн, дүнг гаргаж мэдээлнэ. Энэ тухайгаа дүүргийн сонгуулийн хороонд нэн даруй мэдээлнэ.
4. Баримт бичиг цэгцлэх, хүргүүлэх: Тэмдэглэл болон бусад баримт бичгийг дүүргийн сонгуулийн хороонд нэн даруй хүлээлгэн өгнө.

Техникийн тооллогыг явагдаж дууссанаар саналын дүн гаргах ажиллагаа дуусгавар болно.

ДӨРӨВ. АЖИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Дотоодын байгууллагын ажиглагчийг бэлтгэх үйл явц

Ажиглагчдыг бүрдүүлэхдээ өмнөх сонгуулиудаар ажилласан ажиглагчдын мэдээлэл дээр үндэслэн мэдээлэл хүргэж, бүрдүүлсэн. 5 баг ажилласан бөгөөд багийн ахлагчдыг өмнөх сонгуулиудад ажиглагчаар болон багийн ахлагчаар ажилласан туршлагатай залуусыг сонгосон.

Эхний санал хураалтын ажиглагчаар төслийн багийн зүгээс эрсдэлийг тооцон нийт 150 гаруй ажиглагчаар ажиллах хүсэлтэй хүмүүсийг бүртгэж авч үүнээс 100 ажиглагч 6 дүүрэгт 5 баг болон ажилуулсан.

Хоёр дах санал хураалтанд 3 баг 20 ажиглагч 6 дүүрэгт ажилласан.

2017 оны 6-р сарын 14-ны өдөр. Төслийн багийн анхны уулзалт болж, Ерөнхийлөгчийн сонгуульд хамтран ажиглалт хийхээр тохиролцов.

2017 оны 6-р сарын 16-ны өдөр. Сонгуулийн ажиглалтын багийн ахлагч нарыг сонгон томилж, төслийн үйл ажиллагааг танилцуулж, ажил үүргийн хуваарийн талаар хэлэлцэж, харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

2017 оны 6-р сарын 14-18-ны өдрүүд. Сайн дурын ажиглагч бүрдүүлэх яаралтай үйл ажиллагааны дүнд багийн ахлагч нар өөрсдийн багаа бүрдүүлэв.

Сонгуулийн ажиглагчдыг элсүүлэхдээ дараах шалгуурыг мөрдлөг болгосон. Үүнд:

- сонгуульд оролцох 18 насанд хүрсэн;
- Монгол улсын иргэн;
- сонгуульд идэвхтэй оролцох, сонгуулийг ажиглах хүсэлтэй;
- аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг төлөөлөхгүй, үйлчлэхгүй;
- төвийг сахиж, иргэний нийгмийн, хөндлөнгийн ажиглалтыг сайн дурын үндсэн дээр, хариуцлагатай хийх 18-35 насны иргэний нийгмийн, бие даасан ажиглагчдыг элсүүлэн бүртгэсэн.

2017 оны 6-р сарын 19-22-ны өдрүүд. СЕХ-оос 2016 оны 3-р сарын 23-ны өдөр баталсан “Төрийн бус байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах журам”-д заасан эрхийн дагуу ажиглагчдыг сургалтад хамруулсан. Сургалтын агуулгад сонгуулийн талаарх суурь мэдлэг, сонгуулийн эрх зүйн орчны болон сонгуулийн автоматжуулсан машины талаар тодорхой ойлголт өгөх, аргачлал эзэмшүүлэх оролцоонд суурилсан хагас өдрийн сургалтыг 2 удаа зохион байгуулж нийт ажиглагчдыг бэлтгэсэн. Өмнөх сонгуулиудад ажиглагч хийж байсан туршлагатай ба анх удаа ажиглагч хийх 2 хэсэгт хувааж сургалтыг зохион байгуулсан.

Хагас өдрийн сургалтын агуулга:

- ✓ Нэгдүгээр хэсэг: Сонгуулийн талаар болон сонгуулийн ач холбогдол ба сонгуулийн тухай худал ба үнэн мэдээлэл, сонгуулийн автоматжуулсан системийн талаар,
- ✓ Хоёрдугаар хэсэг: Сонгуулийн тухай хууль, сонгуулийн өдрийн жүжигчилсэн тоглолт (mock election), тус өртөө дээр шалгах хуудсын дагуу зөрчлийг тэмдэглэх хэлбэрээр явагдсан.

Төслийн удирдах багийн гишүүд, багийн ахлагч нар мөн ажиглагчид нь сонгуулийг ажиглахдаа аливаа нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг төлөөлөхгүй, төвийг сахиж, сонгуулийн хууль тогтоомжийн хүрээнд ажиллах Иргэний нийгмийн ажиглагчийн ёс зүйг дурьдсан харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

4.2 Дотоодын байгууллагын ажиглагчаар бүртгүүлэх үйл явц

Сонгуулийн санал авах, санал тоолох, санал хураалтын дүн гаргах ажиллагааг Төрийн бус байгууллагаас буюу Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд ТББ, Бодлогод залуусын хяналт ТББ нар

Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын нийт 6 дүүргийн Ерөнхийлөгчийн сонгуулийн 50 хэсэгт 100 ажиглагчийг зохих журмын дагуу бүртгүүлж, ажиллуулав.

Сонгуулийн үйл явцыг төрийн бус байгууллагаас ажиглагч ажиглах эрх зүйн зохицуулалт:

Сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр бүлэгт ТББ болон улс төрийн намаас ажиглагчийг томилон, сонгуулийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх үйл явц, ажиглагчийн эдлэх эрх, хүлээх үүргийг хуульд тусгасан ба СЕХ-оос баталсан “Төрийн бус байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах журам,”-ийн хүрээнд ажиллаа.

Ажиглагчийг бүртгүүлэх:

Нийслэлийн хэмжээнд санал хураалт явагдах хэсгүүдийг хуулийн хугацаанд багтааж songuuli.ulaanbaar.mn сайт дээр нийтэд ил мэдээлсэн нь албан бичгийг урьдчилан төлөвлөж, хаяг байршлын дагуу олж очиход төвөггүй байв. Харамсалтай нь сайт дээр байршуулсан хэсгүүдийн мэдээлэл нь бүх хэсэг дээр зөрсөн ба дахин хуралдаж, хэсгүүдийн тоог өөрчлөх шийдвэр гаргасанаа залруулж бичээгүй байсан нь ажиглагчдыг бүртгүүлэх ажлын явцыг удаашруулж, албан бичгээ шинээр бичиж дахин очиход хүргэсэн.

Мөн хэсгүүд ажиглагчдыг бүртгэж авах тухай Сонгуулийн Ерөнхий хорооноос бидэнд мэдэгдээгүй, дүүргийн сонгуулийн хорооноос эхлээд зөвшөөрөл ав зэргээр олон дахин буцаах тохиолдолууд гарсан. Мөн Сонгуулийн тухай хуулийн 107-р зүйлд заагдаагүй бичиг баримт нэхэх, нэмэлт тодорхойлолт шаардах, хоёр ажиглагч ээлжээр сэлгэн суухыг хориглох, танхимын багтаамж бага тул хагас өдрөөр бусад намын ажиглагчидтай ээлжлэх хэрэгтэй зэрэг хуульд заагаагүй шаардлагуудыг тавьж, бидний ажилд хүндрэл учруулж байсан нь сонгуулийн хуулийн холбогдох заалтын зорилгыг зөрчсөн гэж дүгнэж байна.

Сонгуулийн хуулийн 2.1-д заасан заасны дагуу бид 100 ажиглагчийг бүртгүүлэхээр “Тухайн байгууллагыг бүртгэсэн тухай СЕХ-ны шийдвэрийн хуулбар, биеийн байцаалтын хуулбар (иргэний үнэмлэх, албан), ажиглагчийн анкет”-ыг бүрдүүлэн тойргийн хороодод сонгууль болох өдрөөс 5-7 хоногийн өмнө хүргүүлсэн.

2017 оны 7-р сарын 7-ны өдрийн дахин сонгуулийн үйл явцыг ажиглахаар 20 ажиглагчийн бүртгүүлсэн ба ихэнх хэсгүүд өмнөх үнэмлэхээ авчраад сунгуулах боломжтой гэж байсан бол зарим хэсэг дээр дахин шинэ материал бүрдүүлж авчрах шаардлагыг тавьсан. Зарим хэсгүүд уртасгасан цагаар ажиллах хуваарийн дагуу ажиллаагүй, цагаасаа

өмнө ажлын байраа орхин явсан зэрэг нь бидний ажилд хүндрэл учруулж байв. Гэсэн ч асуудлыг дор бүр нь Сонгуулийн Ерөнхий хорооны мэдээллийн ажилтантай ярилцаж, хэсгүүд рүү яриулах замаар шийдвэрлэснээр 20 ажиглагчийг хуулийн хугацаанд нь багтаан бүртгүүлж чадсан.

ТАВ. 6-Р САРЫН 26-НЫ САНАЛ ХУРААЛТЫН АЖИГЛАЛТЫН ДҮН

5.1 А – САНАЛ АВАХ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТ

Ажиглалтанд хамрагдсан санал авах байрны дотно болон гадна орчин хуульд заасны дагуу зохион байгуулагдаж, нөхцлийг бүрдүүлсэн эсэх, түүнчлэн автоматжуулсан системийн бэлэн байдал, санал авах ажиллагааны нээлт хуульд заасан журмын дагуу явагдаж буй эсэхийг хянасан ажиглалтын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

• Орчин

Ажиглалтын нэгтгэсэн дүнгээс үзэхэд 85-ээс дээш хувь нь санал авах байрыг хуульд заасан шаардлагын дагуу бэлтгэсэн байжээ. Тухайлбал санал авах байрны орчин, бүрэлдэхүүн бүрэн, аюулгүй байдлыг хангасан, сонгогчийн бүртгэл дэх зургийг нийтэд үзүүлэх дэлгэцийг бэлдсэн, санал тоолох төхөөрөмж бэлэн байдалтай, ил харагдах эвдрэл гэмтэлгүй байсан зэрэг хэсгийн зохион байгуулалт сайн байсан боловч дараах дутагдлууд ажиглагдсан байна.

Иргэний нийгмийн ажиглагчдын 14 хувь нь санал авах байрны дотоод зохион байгуулалт сонгогчдод ойлгомжгүй байна гэжээ. Мөн 72 хувь нь сонгогч саналаа нууцаар гаргах боломжтой байна гэж үзсэн боловч 26 хувь нь санал авах байр хэтэрхий жижиг, санал бэлтгэх бүхээгүүдийг хооронд нь хэт ойр зайтай байрлуулснаас сонгогч саналаа нууцаар бэлтгэх боломж бага, саналын нууцлал алдагдах магадлалтай байсан гэжээ.

Тэргэнцэртэй иргэд саадгүй зорчих налуу замыг хэсгүүдийн 68 хувь нь урьдчилан бэлтгээгүй байсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд саналаа өгөх нөхцлийг бүрдүүлээгүй байна.

Түүнчлэн иргэний нийгмийн ажиглагчдыг санал авах үйл явцыг саадгүй ажиглах боломжтой орчинг 12 хувь нь бий болгоогүй байна. Ажиглагчдад зориулсан ширээ сандал бэлтгээгүй, ширээ сандал хүрэлцэхгүй зэрэг бэрхшээлүүд үүссэн. Ялангуяа жижиг санал авах байрны хувьд намын болон ТББ-ын ажиглагчдыг нэг эгнээнд суулгах боломжгүй учир хэд хэдэн эгнээгээр суудал бэлтгэж, ТББ-ын ажиглагчийг арын эгнээнд суулгасан нь сонгуулийн үйл явцыг бүхэлд нь ажиглах боломжгүй. Эсвэл огт суудал бэлтгээгүйгээс өдөржин зогсох зэргээр ажиглалтын мэдээллийг цуглуулахад хүндрэлтэй нөхцлүүд үүссэн байна.

- **Автоматжуулсан системийн бэлэн байдал**

Автоматжуулсан систем нь сонгогчийн нэрийн жагсаалтын цахим мэдээллийн сан, санал тоолох төхөөрөмж гэсэн үндсэн хоёр бүрэлдэхүүнтэй байсан. Цахим мэдээллийн сангийн хувьд сонгогчийн хурууны хээг таних төхөөрөмж, зөөврийн компьютер, сонгогчийн мэдээллийг харуулах дэлгэц зэргийг санал авах байранд заавал бэлтгэж тавьсан байх ёстой бөгөөд бүх санал авах байранд сонгогчийн бүртгэл дэх зургийг үзүүлэх дэлгэцийг байрлуулсан гэж ажиглагчдын 96 хувь нь хариулсан байна.

Гэхдээ тодорхой аргачлалын дагуу мэдээлэл цуглуулж буй ТББ-ын ажиглагчдын хувьд санал тоолох төхөөрөмж, сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой мэдээллийг цуглуулахад хүндрэлтэй байжээ.

Ялангуяа тэг тайлан хэвлэж өгөхийг хүсэхэд “зохион байгуулах хорооноос хэвлэхгүй гэсэн, зөвхөн намын ажиглагч нарт өгөх ёстой, тайлан хэвлэсний дараа орж ир, угаасаа хэвлэж өгдөггүй, зургийг нь л дар” гэх зэргээр ил тод байдлыг хангахад саад учруулжээ. Иймд ажиглагчдын 98 хувь нь төхөөрөмжийн батерей бүрэн цэнэгтэйг, 70 хувь нь төхөөрөмжийг баталгаажуулсан гэрчилгээтэйг, 98 хувь нь төхөөрөмжид ил харагдах эвдрэл гэмтэл байхгүйг, 82 хувь нь сонгогчийн нэрийн жагсаалтыг хэвлэж бэлтгэсэн байсныг нүдээр харж баталгаажуулж чаджээ.

- **Санал авах ажиллагааг эхлүүлэх**

Иргэний нийгмийн ажиглалт хийсэн хэсгүүдийн 64 хувь нь санал авах ажиллагааг хуульд заасан хугацаа болох өглөөний 07:00 цагт эхлүүлсэн бөгөөд 2 хэсэг цагаасаа өмнө буюу 6:50-6:55 эхэлсэн бол 16 хэсэг 07:05-07:30 минутын хороонд санал авах ажиллагааг эхлүүлсэн байна.

Ажиглагч нартай санал авах ажиллагааны нээлтийн үйл явцыг тодруулан ярилцахад хэсгийн ахлагч нарын түршлагаас хамааран ахлагч нар хийж буй ажиллагааг тайлбарлаагүй, хуулийн дарааллын дагуу явуулаагүй, хэлж байгаа нь ажиглагчдад сонсогдоогүй, асуулт тавихад хариулахгүй байх зэрэг шалтгааны улмаас ажиглалтын мэдээлэл авахад хүндрэлтэй байжээ.

Ажиглалт хийсэн хэсгүүдийн 92 хувь нь санал авах бүх хайрцгийг нээж харуулан шалгасан (2 хэсэг харуулаагүй), 64 хувь зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгсөн сонгогчдын бүртгэлийн хуудсыг хэвлэж бэлтгэсэн (18 хувь нь хариулаагүй), 64 хувь нь хүлээж авсан, зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгсөн, алдагдаж үрэгдсэн, устсан, үлдсэн саналын хуудасны тоог зарласан (18 хувь нь хариулаагүй), 24 хувь нь саналын хуудасны индекс дугаарыг зарласан, 56 хувь саналын хуудасны индекс дугаарыг зарлаагүй гэжээ.

Мөн эхлэлийн тэг тайлан хуудсыг 98 хувь нь хэвлэсэн. Үүнээс 70 хувь нь ажиглагчдад төхөөрөмжийг шалгасан хуудсыг цаасан хэлбэрээр өгчээ. Тэг тайланг авч чадаагүй

ажиглагчдын тэмдэглэлийг үзэхэд зохион байгуулах хорооноос хэвлэхгүй гэсэн, зөвхөн намынханд өгөөрэй гэсэн, тайлан хэвлэсний дараа орж ир, угаасаа өгдөггүй, зургийг нь авч болно зэрэг тайлбарууд өгсөн байна. Мөн тэг тайлантай танилцсан ажиглагчдын **96 хувь нь ямар нэг алдаа байхгүй, тайлан хэвлэлт тод болон хэвийн байсан гэж хариулсан.** Ийнхүү хэсгүүдийн 60 хувь санал авах нээлтийн ажиллагааг нэг бүрчлэн баримтжуулж тэмдэглэл хөтөлсөн гэсэн (30 хувь нь үгүй, 10 хувь нь хариулаагүй) бөгөөд тэмдэглэлд хэсгийн дарга, нарийн бичгийн дарга болон бүх гишүүд гарын үсэг зурсан эсэхийг асуусан асуултанд 38 хувь нь “тийм,” 40 хувь нь “үгүй,” 22 хувь нь хариулаагүй байна. Түүнчлэн тэмдэглэл хөтөлсөн хэсгүүдийн 26 хувь нь ТББ-ын ажиглагчаар гарын үсэг зурруулж, 54 нь гарын үсэг зурруулаагүй байна.

5.2 Б - САНАЛ АВАХ АЖИЛЛАГАА

- Санал авах ажиллагаа

Санал авах ажиллагааны үед санал авах байранд аль нэгэн нам эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаа хийгдсэн эсэх гэсэн асуултанд нийт ажиглагчдын 5.3 хувь нь “тийм” гэсэн хариултыг өгсөн байна. Нэг сонгуулийн хэсэгт намуудын логог байрлуулсан байсан байна. Тухайн ажиглагчдын тэмдэглэснээр зарим намын ажиглагчид хэсгийн байрны гадаа хэд, хэдэн сонгогчтой уулзсан байна.

Саналаа өгөхөөр ирсэн сонгогчдын хурууны хээг уншуулж саналын хуудсыг олгосон байна. Долоовор хурууны хээ уншихгүй тохиолдолд бусад хурууны хээг уншуулсан бол зарим хэсэгт хурууны хээ уншаагүй тул регистрийн дугаарыг оруулж бүртгэсэн. 155 хүнийг иргэний үнэмлэхийг давхар нягталж шалгалгүйгээр шууд регистрийн дугаараар оруулсан байна. Сонгогчийн нэрсийн жагсаалтанд бүртгэгдсэн сонгогч тус бүрт бүртгэлийн хуудас хэвлэж олгосон байна.

Ажиглалт хийгдсэн хэсгүүдийн 5.3 хувьд нь сонгогч саналаа санал бэлтгэх бүхээгт нууцаар гаргаагүй тохиолдол бүртгэгдсэн. Ийнхүү хариулсан ажиглагчдын тэмдэглэлд нэгдүгээрт, сонгогчид санал бэлтгэх бүхээгт очоод хамт яваа хүмүүс хоорондоо ярих нэрийдлээр хэнд санал өгөхөө ярилцсан ба сонгосон хүнээ чангаар илэрхийлсэн нэг тохиолдол, өөр хүний өмнөөс санал өгсөн нэг тохиолдол тус тус тэмдэглэгдсэн байна. Хоёрдугаарт, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн өмнөөс бөглөх, итгэмжлэгдсэн төлөөлөгч, гэр бүлийн хүн нь өмнөөс нь бөглөх зэргээр нууцаар саналаа гаргахад нь саад учруулсан байна.

Хуульд заасны дагуу саналаа биечлэн өгөх боломжгүй иргэн итгэмжлэгдсэн хүний тусалцаа авах явдал нийт хэсгүүдийн 40.4 хувьд нь ажиглагдсан ба 26.3 хувьд нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс өөр хүн сонгогчийн өмнөөс саналын хуудсыг бөглөсөн байна. Үүний 5.3 хувьд сонгуулийн хэсгийн гишүүн, 1.8 хувьд нэр дэвшигчийн шадар туслах,

ухуулагч зэрэг итгэмжлэгдсэн хүн байж болохгүй этгээд туслалцаа үзүүлсэн тохиолдлууд гарсан байна.

Ажиглагчдын 64.9 хувь нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид уншуулахад хүндрэл гарсан гэж хариулсан ба сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хэрхэн уншуулах талаар хангалттай мэдээлэлгүйн улмаас саналын хуудсыг нугалсан, хавтастай нь хамт хийх гэж оролдсон зэрэг тохиолдлууд гарсан. Мөн нэгээс илүү нэр бөглөсөн ба нэг ч нэр дэвшигчийг бөглөөгүй тохиолдлууд гарсан бөгөөд эдгээрийн заримд сонгуулийн хэсгийн ажилтнууд сонгогчийн эрхийн талаар хангалттай ойлголтгүйн улмаас сонгогчтой үл ойлголцох, аль нэгийг нь заавал бөглөхийг сануулах зэрэг асуудлууд үүссэн байна. Ийнхүү ажиглагчдын 50.9 хувь нь сонгогч саналаа санал тоолох төхөөрөмжид уншуулах үед саналын нууцлал алдагдаж болзошгүй нөхцөл байдал үүсэн хэмээн тэмдэглэсэн байна.

Эдгээрээс шалтгаалан заримдаа санал тоолох төхөөрөмж гацаж мэдээлэл технологийн даамал санал тоолох машиныг унтрааж асаах тохиолдол гарсан байна.

Ажиглалт хийсэн хэсгүүдийн 50.9 хувьд нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид уншуулах үед саналын нууцлал алдагдаж болзошгүй нөхцөл үүссэн гэж тэмдэглэгджээ. Ингэж хариулсан нийтлэг шалтгаан нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийх үед сонгогчид бэрхшээл учирсан тохиолдолд мэдээллийн технологийн даамал болон хэсэгны гишүүд туслалцаа үзүүлэх нэрээр санал өгсөн байдлыг харж байсан байна.

- **Санал авах ажиллагааны зөрчил**

Нийт хэсгүүдийн 3.5 хувьд нь (уг хэсэг тус бүр дээр 10-аас доош тооны) сонгогчийн нэр давхар бүртгэгдсэн тохиолдол гарсан байна. Тухайлбал өрхийн бүртгэл дээр тухайн хаяганд оршин суудаггүй хүний нэр байх тохиолдол гарсан байна.

Мөн хэсэгдын 52.6 хувьд (уг хэсэг тус бүр дээр 10-аас доош тооны) нэрсийн жагсаалтанд бүртгэгдээгүй сонгогч гарч ирсэн байна. Эдгээрийн нийтлэг шалтгаан нь хэсгээ андуурсан гэж тэмдэглэгджээ.

Хэсгүүдын 22.8 хувьд нэрсийн жагсаалтанд сонгогч нэмж бүртгэсэн тохиолдол гарсан байна. Энэ нь “хаяг дээр байхгүй хүнийг нэрсийн жагсаалтанд нэмсэн” бас “түр хасав” гэсэн бүртгэлтэй хүмүүс хүсэлтээ бичин бүртгэлээ сэргээж сонгогчийн бүртгэлийн хуудас авснаар саналаа өгсөн тохиолдлууд байна. Мөн байхгүй нэг хаяг дээр 5 хүн саналаа өгсөн тохиолдол бүртгэгдсэн байна.

Хэсгүүдийн 26.3 хувьд нь (үг хэсэг тус бүр дээр 10-аас доош тооны) сонгогч түр хасагдсан хүмүүсийг бүртгээгүй ба шинэ газар нүүж ирээд хаягийн шилжилт хийлгээгүй байх тохиолдлууд бүртгэгджээ.

Санал авах ажиллагааны үед сонгогч сонгуулийн хэсгийн гишүүдэд гомдол гаргасан тохиолдол нийт хэсэгдын 64.9 хувьд нь (үг хэсэгд тус бүр дээр 10-аас доош тооны) ажиглагдсан байна. Иргэд хамгийн ихээр гомдол гаргаж байсан үндэслэл нь хаяган дээр танихгүй хүн бүртгэлтэй талаар байсан. Мөн саналын хуудастай холбоотойгоор хэсгүүдийн 40.4 хувьд гомдол тэмдэглэгдсэн ба саналын хуудасны хавтастай холбоотой гомдлууд бүртгэгджээ.

Нийт хэсгийн 66.7 хувьд нь сонгогч ямар нэг байдлаар зөрчил гаргасан тохиолдол бүртгэгдсэн. Сонгогчдын түгээмэл гаргасан зөрчил нь саналын хуудсаа буруу бөглөсөнтэй холбоотой байсан. Түүнчлэн өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүний өмнөөс хамт яваа хүн бөглөсөн зөрчил гаргажээ.

Хэсгүүдийн 35.5 хувьд нь саналын хуудастай холбоотой зөрчил гарсан гэж ажиглагчид бүртгэсэн байна. Нийтлэг буюу удаа дараа бүртгэгдсэн тохиолдлууд нь саналын хуудсан дээр буруу тэмдэглэгээ хийсэн, мандатын тооноос илүү дугуйлсан, саналын хуудсыг нугалсан зэрэг байна.

Нам, эвсэл, нэр дэвшигчийн ажиглагчдаас санал, гомдол гаргасан тохиолдол хэсгүүдийн 47.4 хувьд нь гарсан. Тэдгээрийн санал, гомдол гаргасан үндэслэлийг дурдвал бүхээгт санал өгч буй хүмүүс нэгнийхээ саналыг харж хоорондоо ярилцаж байна, санал авах хэсэг тавтай тухтай нөхцөл хангаж, байрыг сайтар зохион байгуулаагүй байна, хяналтын дэлгэц хол мэдээлэл харах боломжгүй, сонгогч утас ашиглаж байна, түр хасав төлөвтэй холбоотой асуудал үүслээ, даамал машинтай хэт ойр зогсож саналыг хуудсыг барьж байна, хурууны хээ танихгүй хүнийг иргэний үнэмлэхээр бүртгэсэн, мэдээлэл дутуу, хэт нам дуугаар өглөө зэрэг гомдол гаргасан байна.

Санал авах ажиллагааны үеэр гарсан санал гомдлыг нийт хэсгийн 52.6 хувьд нь хэсгийн ахлагч хүлээн авч тэмдэглэл хөтлөсөн байна. Мөн ажиглагчдыг санал гомдлыг ойшоохгүй өнгөрөх хандлага илэрч байсан байна. Мөн гомдлыг хүлээн авсан тохиолдолд тухайлсан тохиолдлуудад шийдвэрлэхдээ 57.9 хувьд нь тэмдэглэл хөтлөсөн ба зарим тохиолдолд албан бланк бүс тэмдэглэлийн дэвтэр, бичгийн цаас ашигласан байна.

- **Санал тоолох төхөөрөмжийн саатал, гэмтэл**

Ажиглалтад хамрагдсан хэсгүүдийн 21.1 хувьд нь санал авах ажиллагааны үед санал тоолох төхөөрөмж, түүний иж бүрдэлд ямар нэгэн байдлаар саатал гацалт, түр зогсолт учирсан. Үүнээс хавтасаа хамт хийж гацаасан, гурван нэр дэвшигчийг бүгдийг будсан нь сонгогч гарч явсны дараа буцаж гарч ирсэн, цаасны бөөгнөрөл болсон, саналын хуудас уншихгүй гацсан, дэлгэцийн тохиргоо алдсан учир хар машиныг унтраасан байна. 17.5 хувьд толгой бохирдож, толгой цэвэрлэх хуудсыг уншуулсан.

Нийт хэсгийн 3.5 хувьд нь санал авах байрны тог тохиолдлын чанартай 7 минутын хугацаанд тасарсан.

Хэсгүүдийн 93 хувьд нь санал авах ажиллагаа завсарлагагүй, үргэлжлэн явагдсан байна.

5.3 В – САНАЛ ТООЛОХ, САНАЛ ХУРААЛТЫН ДҮН ГАРГАХ, ТЕХНИКИЙН ТООЛЛОГО

Сонгуулийн өдрийн үйл явц нь саналыг тоолж, дүнг нэн даруй дамжуулж, сонгогдсон хэсэгт техникийн тооллого хийгдэж дүнг нягталснаар үндсэндээ дуусгавар болдог. Нийт 50 хэсэгт биечлэн ажилласан ажиглагчдын мэдээлэлд тулгуурлан үйл явц тус бүрээр мэдээллийг нэгтгэв.

- **Санал тоолох ажиллагааны бэлтгэл**

Хуульд зааснаар санал авах ажиллагаа 22 цагт дуусах ёстой. Ажиглалтанд хамрагдсан хэсэгдын 96хувь нь тус цагийг баримталж, үлдсэн хэсэгдод 22:05 цаг гэхэд санал авах үйл явц дуусчээ. Энэхүү ажиллагаа дуусахад хэсэгдын 90хувьд сонгогчийн бөөгнөрөл үүсээгүй байна. Харин 3 хэсэгны мэдээллийг нэгтгэхэд 50 орчим хүн саналаа өгч чадаагүй гэжээ.

Санал авах ажиллагаа дуусмагц хуульд заасны дагуу санал тоолох үйл явц шууд үргэлжлэх бөгөөд 80хувьд нь санал тоолох ажиллагааны талаарх хэсэгны ажлын зохион байгуулалт тодорхой байж, 78хувьд ажил үүргийн хуваарийг урьдчилан баталж, 74хувьд нь тэмдэглэл хөтлөх үүргийг тусгайлан хүлээсэн гишүүн ажиллажээ. Энэ нь хэсэгдын зохион байгуулалтыг жигдрүүлэхэд анхаарах шаардлагатайг харуулж байна.

Мөн ажиглагчдын 96хувьд санал тоолох үйл ажиллагааг бүхэлд нь ажиглаж болохуйц нөхцлийг бүрдүүлсэн байна.

- **Санал тоолох ажиллагаа**

Ажиглалт хийгдсэн хэсэгдын 86хувьд санал тоолох ажиллагаа завсарлалгүй шууд явагдсан бөгөөд санал тоолох ажиллагаанд ноцтой нөлөөлөхүйц зөрчил, дутагдал ажиглагдаагүй байна. Энэ ажиллагаа нь ерөнхийдөө хуульд заасан журмын дагуу хэвийн явагдсан боловч дараах асуудлуудад анхаарах шаардлагатай нь ажиглалтын дүнгээс харагдаж байна.

Санал тоолох ажиллагаанд зарцуулаагүй болон буруу тэмдэглэснээс хураагдсан саналын хуудсыг тоолж, хүчингүй болгон битүүмжлэх ажиллагаа ажиглагчдад ил тод, зайлшгүй хийгдэх шаардлагатай. Нийт хэсгийн 74хувь зарцуулаагүй, 80хувь нь хураагдсан саналын

хуудасны баруун дээд өнцгийг хайчлан хүчингүй болгосноо ажиглагчдад харагдахуйцаар зохион байгуулжээ.

Мөн сонгогчийн нэрсийн жагсаалтанд “түр хасав” төлөвтэй хүмүүсийг сэргээж санал өгүүлсэн тохиолдолд тус тайланг гаргаж, мэдээлэх үүрэгтэй бөгөөд бөгөөд хэсэгдын 72хувь нь ажиглагчдад дүнг танилцуулсан байна.

- **Санал хураалтын дүн гаргах**

Сонгуулиар санал хураалтын дүнг төв серверт дамжуулж, нэгтгэгдэж буй дүнг телевизээр орон даяар шууд цацагддаг.

Ажиглагчдын тэмдэглэснээр бүх хэсэг буюу 100хувь нь төхөөрөмж тус бүрийн дүнгийн тайланг хэвлэж, 95хувь нь саналын хуудасны дүнг ажиглагчдад хэвлэж өгсөн ба 98хувь нь тайлангуудын үзүүлэлтийг нэгтгэсэн дүнг гаргажээ. Ийнхүү 84хувь нь уншиж сонсон, 94хувь нь сонгуулийн төв байгууллагад тусгай модем ашиглан нэн даруй мэдээлжээ. Харин дүнг дамжуулахад 20-30 минут зарцуулсан 13 хэсэг байжээ.

Хэдийгээр төхөөрөмжинд тоологдсон саналын дүнг нийтэд шууд цацагдсан боловч санал тоолох ажиллагааны үйл явц хэсэгд дээр үргэлжилж, тодорхой алхмуудаар дүнг баталгаажуулахаар хуульд заасан. Энэхүү үйл явцыг баримтжуулсан тэмдэглэлд хэсэгдын 22хувь хувь оролцогчдоор гарын үсэг зурүүлж, 70хувь нь санал хураалтын дүнгийн тухай тогтоолыг үйлдэж, хуралдаанаар хэлэлцэн баталжээ. Мөн 82хувьд нь саналын хуудасны зурган файлыг иргэний бүртгэлийн компьютерт хуулж өгсөн ажиглагчдад харагдсан ба 98хувь нь ажиглагчдад CD дээр хуулж өгсөн. Техникийн мэдлэг болон бэлтгэл хангалтгүй, зурган файлыг хуулж авах хүсэлтээ бичгээр гаргах, заавал DVD авчрахыг шаардах зэрэг хүндрэл учирч байсан.

Түүнчлэн хэвлэгдсэн тайлангийн үзүүлэлтийг санал өгсөн сонгогчдын тоо, зарцуулсан саналын хуудасны тоотой харьцуулах ёстой бөгөөд 68хувьд нь ямар нэг зөрүү гараагүй. Харин зөрүү гарсан гэж тэмдэглэсэн хэсгүүд зөрүүг гаргасан гэж тэмдэглэжээ.

- **Санал тоолох ажиллагааны зөрчил**

Ажиглалт хийсэн хэсэгдод санал тоолох ажиллагааны үед сонгуулийн үр дүнд нөлөөлөх ноцтой зөрчил, саатал, будлиантуулах оролдлого ажиглагдаагүй байна.

Гэхдээ 4 хэсэгт техникийн тооллого хийх эсэхийг хүлээснээс завсарласан, 3 хэсэгт төхөөрөмжийн тусгай түлхүүр мэдээлэл технологийн даамлаас өөр хүнд хадгалагдаж байсан, 2 хэсэгт санал тоолох ажиллагааны үед санал тоолох төхөөрөмж гацсан гэж тэмдэглэжээ.

- **Санал тоолох төхөөрөмжийн саатал гэмтэл**

Санал тоолох ажиллагааны үед санал тоолох төхөөрөмжид саатал гарсан тохиолдол 2 хэсэгт тохиолджээ. Энэ нь санал хэвлэх явцад цаас нь бөөгнөрснөөс болсон гэж тэмдэглэсэн байна.

- **Техникийн тооллого:**

Төрийн бус байгууллагын ажиглалтыг зохион байгуулах багийн төлөөлөл 6 дүүргийн техникийн тооллого явагдах хэсэгдыг сугалах ажиллагаанд хөндлөгийн ажиглалт хийж оролцсон. Ийнхүү бидний ажилласан 50 хэсгээс 23 хэсэг сугалаагаар сонгогдож, ажиглалтыг үргэлжлүүлсэн.

Ажиглагчдын мэдээллээс үзэхэд техникийн тооллого явагдах үйл явц 100хувь ажиглагчдад нээлттэй явагдсан ба СЕХ-оос баталсан журмын дагуу явагджээ. Техник тооллого дунджаар 1 цаг 30 минутын дараа эхэлсэн ба дунджаар 3-8 цаг үргэлжилсэн.

Техникийн тооллого хийгдсэн хэсгүүдэд санал тоолох машины дүн болон гараар хянаж тоолсон дүнгийн зөрүү гараагүй байна. Нэг хэсэгт саналын хуудас болон санал авах машины санал зөрөх тохиолдол гарсан гэж тэмдэгдсэн боловч энэ саналын хуудсыг бөглөхдөө нэр дэвшигчийн өмнөх дүгийг тойруулан тэмдэглэсэнтэй холбоотой байж болзошгүй. Мөн хэсгүүдийн ажилчид олон цаг ажилласны улмаас алдаж тоолсон байж болзошгүй юм.

6.1 А – САНАЛ АВАХ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТ

Хоёр дах санал хураалтын өдрийн ажиглалтаар нийт 20 хэсэгт ажилласан. Баянгол дүүрэгт 2, Баянзүрх дүүрэгт 6, Сонгинохайрхан дүүрэгт 4, Сүхбаатар дүүрэгт 4, Хан-Уул дүүрэгт 1, Чингэлтэй дүүрэгт 3 хэсэгт тус тус иргэний нийгмийн ажиглагч нар бүтэн өдрөөр сонгуулийн үйл явцыг ажиглалаа. Ажиглалтанд хамрагдсан санал авах байрны дотно болон гадна орчин хуульд заасны дагуу зохион байгуулагдаж, нөхцлийг бүрдүүлсэн эсэх, түүнчлэн автоматжуулсан системийн бэлэн байдал, санал авах ажиллагааны нээлт хуульд заасан журмын дагуу явагдаж буй эсэхийг хянасан ажиглалтын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

• Орчин

Ажиглалтын нэгтгэсэн дүнгээс үзэхэд 90-ээс дээш хувь нь санал авах байрыг хуульд заасан шаардлагын дагуу бэлтгэсэн байжээ. Тухайлбал санал авах байрны орчин, бүрэлдэхүүн бүрэн, аюулгүй байдлыг хангасан, сонгогчийн бүртгэл дэх зургийг нийтэд үзүүлэх дэлгэцийг бэлдсэн, санал тоолох төхөөрөмж бэлэн байдалтай, ил харагдах эвдрэл гэмтэлгүй байсан зэрэг хэсгүүдийн зохион байгуулалт сайн байсан боловч дараах дутагдлууд ажиглагдсан байна.

Иргэний нийгмийн ажиглагчдын 5 хувь нь санал авах байрны дотоод зохион байгуулалт сонгогчдод ойлгомжгүй байна гэжээ. Мөн 75 хувь нь сонгогч саналаа нууцаар гаргах боломжтой байна гэж үзсэн боловч 25 хувь нь санал авах байр хэтэрхий жижиг, санал бэлтгэх бүхээгүүдийг хооронд нь хэт ойр зайтай байрлуулснаас сонгогчийн саналын нууцлал алдагдах магадлалтай байсан гэжээ.

Тэргэнцэртэй иргэд саадгүй зорчих налуу замыг хэсгүүдийн 60 хувь нь урьдчилан бэлтгээгүй байсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд саналаа өгөх нөхцлийг бүрдүүлээгүй. Иргэний нийгмийн ажиглагчдыг санал авах үйл явцыг саадгүй ажиглах боломжтой орчинг 5 хувь нь буюу нэг хэсэг бий болгоогүй байсан гэж хариулжээ.

- **Автоматжуулсан системийн бэлэн байдал**

Автоматжуулсан систем нь сонгогчийн нэрийн жагсаалтын цахим мэдээллийн сан, санал тоолох төхөөрөмж гэсэн үндсэн хоёр бүрэлдэхүүнтэй байсан. Цахим мэдээллийн сангийн хувьд сонгогчийн хурууны хээг таних төхөөрөмж, зөөврийн компьютер, сонгогчийн мэдээллийг харуулах дэлгэц зэргийг санал авах байранд заавал бэлтгэж тавьсан байх ёстой бөгөөд бүх санал авах байранд сонгогчийн бүртгэл дэх зургийг үзүүлэх дэлгэцийг байрлуулсан гэж ажиглагчид 100 хувь нь хариулсан байна.

10 хоногийн өмнө ажиглалт хийхэд гарч байсан хүндрэлүүд зарим хэсэг дээр дахин гарсан байна. Жишээ нь санал тоолох төхөөрөмж, сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой мэдээллийг цуглуулах, ялангуяа тэг тайлан хэвлэж өгөхийг хүсэхэд “хэвлэж өгөхгүй байх шийдвэр гарсан” гэх шалтгаанаар ил тод байдлыг хангахад саад учруулжээ.

Ажиглагчдын 98 хувь нь төхөөрөмжийн батерей бүрэн цэнэгтэйг, 95 хувь нь төхөөрөмжийг баталгаажуулсан гэрчилгээтэйг, хувь нь төхөөрөмжид ил харагдах эвдрэл гэмтэл байхгүйг, 75 хувь нь сонгогчийн нэрийн жагсаалтыг хэвлэж бэлтгэсэн байсныг нүдээр харж баталгаажуулжээ.

- **Санал авах ажиллагааг эхлүүлэх**

Иргэний нийгмийн ажиглалт хийсэн 20 хэсгийн 80 хувь нь санал авах ажиллагааг хуульд заасан хугацаа болох өглөөний 07:00 цагт эхлүүлсэн гэж хариулсан ба 20 хувь нь буюу 4 хэсэгт цагтаа эхлээгүй. Үүнээс нэг хэсэг цагаасаа өмнө 6:55 эхэлсэн бол 3 хэсэг 07:05-07:15 минутын хороонд санал авах ажиллагааг эхлүүлсэн байна.

Ажиглалт хийсэн хэсгүүдийн 85 хувь нь санал авах бүх хайрцгийг нээж харуулан шалгасан, 90 хувь нь зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгсөн сонгогчдын бүртгэлийн хуудсыг хэвлэж бэлтгэсэн, 65 хувь нь хүлээж авсан, зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгсөн, алдагдаж үрэгдсэн, устсан, үлдсэн саналын хуудасны тоог зарласан, 20 хувь нь саналын хуудасны индекс дугаарыг зарласан, 65 хувь саналын хуудасны индекс дугаарыг зарлаагүй гэжээ.

Түүнчлэн эхлэлийн тэг тайлан хуудсыг 95 хувь нь хэвлэсэн. Үүнээс 70 хувь нь ажиглагчдад төхөөрөмжийг шалгасан хуудсыг цаасан хэлбэрээр өгчээ. Тэг тайланг авч чадаагүй 3 хэсгийн ажиглагчийн тэмдэглэлийг үзэхэд “хэвлэж өгөхгүй байх шийдвэр гарсан” гэдэг тайлбар өгсөн байна. Мөн тэг тайлантай танилцсан ажиглагчдын 95 хувь нь ямар нэг алдаа байхгүй, тайлан хэвлэлт тод болон хэвийн байсан гэж хариулсан. Ийнхүү

хэсгүүдийн 60 хувь санал авах нээлтийн ажиллагааг нэг бүрчлэн баримтжуулж тэмдэглэл хөтөлсөн гэсэн (35 хувь нь үгүй, 5 хувь нь хариулаагүй) бөгөөд тэмдэглэлд хэсгийн дарга, нарийн бичгийн дарга болон бүх гишүүд гарын үсэг зурсан эсэхийг асуусан асуултанд 30 хувь нь “тийм,” 60 хувь нь “үгүй,” 10 хувь нь хариулаагүй байна.

6.2 Б – САНАЛ АВАХ АЖИЛЛАГАА

- **Санал авах ажиллагаа**

Санал авах ажиллагааны үед санал авах байранд аль нэгэн нам эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаа хийгдсэн эсэх гэсэн асуултанд нийт ажиглагчдын 10 хувь нь “тийм” гэсэн хариултыг өгсөн байна. Мөн намуудаас сонголтод нөлөөлөх үйл ажиллагаанууд явуулсан байна. Үүнд СБД-ийн 1860-р хэсэгт МАХН-ын дарга Н.Энхбаяр “Цагаан сонголт” гэсэн бичигтэй подволктой орж ирсэн ба өөр хэсэгт МАН-ын ажиглагч байнга хүүхдийн мөнгөний талаар хэлж байсан талаар тэмдэглэгдсэн байна.

Сонгуулийн хэсгийн 90 хувьд саналаа өгөхөөр ирсэн сонгогчдын хурууны хээг уншуулж саналын хуудсыг олгосон байна. Долоовор хурууны хээ уншихгүй тохиолдолд 100 хувь бусад хурууны хээг уншуулсан бол зарим хэсэгт хурууны хээ уншаагүй тул регистрийн дугаарыг оруулж бүртгэсэн. Сонгогчийн нэрсийн жагсаалтанд бүртгэгдсэн сонгогчдын 80 хувьд бүртгэлийн хуудас хэвлэж олгосон байна.

Ажиглалт хийгдсэн хэсэгдын 5 хувьд нь сонгогч саналаа санал бэлтгэх бүхээгт нууцаар гаргаагүй тохиолдол бүртгэгдсэн. Хуульд заасны дагуу саналаа биечлэн өгөх боломжгүй иргэн итгэмжлэгдсэн хүний туслалцаа авах явдал нийт хэсэгдын 45 хувьд нь ажиглагдсан. Итгэмжлэгдсэн хүмүүсийн 10 хувьд нь итгэмжлэгдсэн төлөөлөгч бус сонгуулийн хэсгийн гишүүн, дарга нар туслалцаа үзүүлсэн тохиолдлууд гарсан байна.

Ажиглагчдын 40 хувь нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид уншуулахад хүндрэл гарсан ба 45 хувь нь нууцлал алдагдагдаж болзошгүй байсан гэж хариулсан ба сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хэрхэн уншуулах талаар хангалттай мэдээлэлгүйн улмаас саналын хуудсыг нугалсан, хавтастай нь хамт хийх гэж оролдсон зэрэг тохиолдлууд гарсан. Мөн нэг ч нэр дэвшигчийг бөглөөгүй сонгогчийг намын ажиглагч үгээр сүрдүүлсэн, 2 хүнийг зэрэг дугуйлбал машин хүлээж авахгүй гэж тайлбарласан, мэдээллийн технологийн даамал ойр суусан, намын ажиглагчил таньдаг хүмүүсээ нэрээр нь дуудаж байсан зэрэг зөрчлүүд бүртгэгдсэн байна.

- **Санал авах ажиллагааны зөрчил**

Нийт хэсгүүдийн 35 хувьд нь сонгогчийн нэр давхар бүртгэгдсэн тохиолдол гарсан байна. Тухайлбал өрхийн бүртгэл дээр тухайн хаяганд оршин суудаггүй хүний нэр байх тохиолдол гарсан байна.

Мөн хэсгүүдийн 70 хувьд нь нэрсийн жагсаалтанд бүртгэгдээгүй сонгогч гарч ирсэн байна. Эдгээрийн нийтлэг шалтгаан нь хэсэггоо андуурсан, иргэний үнэмлэхгүй эсвэл түр хасалттай хүмүүс ирсэн ба гэрийн хаягтай ч нэрсийн жагсаалтанд байгаагүй гэж тэмдэглэгджээ.

Хэсгүүдийн 20 хувьд нэрсийн жагсаалтанд сонгогч нэмж бүртгэсэн тохиолдол гарсан байна. Энэ нь “хаяг дээр байхгүй хүнийг нэрсийн жагсаалтанд нэмсэн” тохиолдлууд байна. Мөн 15 хувьд бичиг баримтын зөрчил гарсан байна.

Санал авах ажиллагааны үед сонгогч гомдол гаргасан тохиолдол 75 хувьд нь (үг хэсэгд 60 хувьд 10-аас доош тооны) ажиглагдсан байна. Иргэд гомдол гаргаж байсан үндэслэл нь бүртгэлийн цагаан хуудас өгөхгүй байна, саналын хуудас хураалгахгүй, хуруун дээр тэмдэглэгээ хийлгэхгүй, хаяган дээр танихгүй хүн бүртгэлтэй болон зөөврийн саналын хайрцгаар санал өгөх өргөдөл өгсөн ч очоогүй тухай байсан. Мөн саналын хуудастай холбоотойгоор хэсгүүдийн 35 хувьд зөрчил тэмдэглэгдсэн ба саналын хуудасны хавтастай холбоотой гомдлууд бүртгэгджээ.

75 хувьд нь сонгогч ямар нэг байдлаар зөрчил гаргасан (65 хувьд нь 10-аас доош) тохиолдол бүртгэгдсэн. Сонгогчдын түгээмэл гаргасан зөрчил нь бэхэн тэмдэглэгээ хийлгэхээс татгалзсан, гэрэл зураг дарсан, бичлэг хийсэн, хэрүүл маргаан гаргасан, саналын хуудсаа буруу бөглөсөнтэй холбоотой байсан.

35.5 хувьд нь саналын хуудастай холбоотой зөрчил гарсан гэж ажиглагчид бүртгэсэн байна. Нийтлэг буюу удаа дараа бүртгэгдсэн тохиолдлууд нь саналын хуудсаа буруу бөглөсөн зэрэг байна.

Нам, эвсэл, нэр дэвшигчийн ажиглагчдаас хэсгүүдийн санал, гомдол гаргасан тохиолдол хэсэгдын 25 хувьд нь гарсан. Тэдгээрийн санал, гомдол гаргасан үндэслэлийг дурдвал сонгогч нэг ч нэр дэвшигчийг бөглөхгүй байна, даамал хүний өмнөөс санал уншуулсан, чихэр тараасан, хурууны хээ танихгүй байхад иргэний үнэмлэхээр бүртгэлээ зэрэг гомдол гаргасан байна.

Санал авах ажиллагааны үеэр гарсан санал гомдлыг нийт хэсгийн 45 хувьд нь хэсгийн ахлагч хүлээн авч тэмдэглэл хөтлөсөн байна.

- **Санал тоолох төхөөрөмжийн саатал, гэмтэл**

Ажиглалтад хамрагдсан хэсэгдын 30 хувьд толгой бохирдож, толгой цэвэрлэх хуудсыг уншуулж түр саатсан байна.

Нийт хэсгийн 5 хувьд нь санал авах байрны тог тохиолдлын чанартай 7 минутын хугацаанд тасарсан. 90 хувьд нь санал авах ажиллагаа завсарлагагүй, үргэлжлэн явагдсан байна. Мөн нэг хэсэгт ТББ-ын ажиглагчид СД өгөөгүй байна.

6.3 В – САНАЛ ТООЛОХ, САНАЛ ХУРААЛТЫН ДҮН ГАРГАХ, ТЕХНИКИЙН ТООЛЛОГО

2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль нь хоёр шаттай болж өнгөрсөн. Иймд хоёр дах санал хураалтын өдөр 6 дүүргийн 20 хэсэгт иргэний нийгмийн ажиглалт хийсэн.

Эдгээр хэсэгт 100хувьд нь санал тоолох ажиллагаа завсарлаагүй, санал тоолох төхөөрөмжинд саатал гараагүй буюу ноцтой зөрчил дутагдал ажиглагдаагүй байна. Гэхдээ зарим асуудлыг дурдвал:

- Гурван хэсэгт түр хасав төлөвт байгаа хүмүүсийг сэргээж бүртгэсэн тайланг гаргаагүй
- Хоёр хэсэгт тайлангуудын үзүүлэлтийг нэгтгэж дүнг гаргаагүй
- Дөрвөн хэсэгт санал хураалтын дүнгийн тухай тогтоолыг үйлдэж, хуралдаанаар хэлэлцэн батлаагүй бөгөөд гурван хэсэгт санал тоолох төхөөрөмжөөс хэвлэн гаргасан санал хураалтын дүнгийн тайланг хуралдаанд уншиж сонсгоогүй
- Нэг хэсэгт саналын хуудасны зурган файлыг иргэний бүртгэлийн компьютерт хуулж өгөөгүй бөгөөд ажиглагчид CD дээр хуулж өгөөгүй гэж тэмдэглэгджээ.

Техникийн тооллого: Төрийн бус байгууллагын ажиглалтыг зохион байгуулах багийн төлөөлөл 6 дүүргийн техникийн тооллого явагдах хэсэгдыг сугалах ажиллагаанд хөндлөгийн ажиглалт хийж оролцсон. Ийнхүү бидний ажилласан 20 хэсгээс 11 хэсэг нь сугалаагаар сонгогдож, ажиглалтыг үргэлжлүүлсэн.

Ажиглагчдын мэдээллээс үзэхэд техникийн тооллого явагдах үйл явц ажиглагчдад нээлттэй явагдсан ба СЕХ-оос баталсан журмын дагуу явагджээ. Техникийн тооллого хийгдсэн хэсгүүдэд санал тоолох машины дүн болон гараар хянаж тоолсон дүнгийн зөрүү гараагүй байна.

6.4 НИЙТ АЖИГЛАЛТ ХИЙХЭД ТУЛГАРСАН ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

2017 оны Ерөнхийлөгчийн хоёр шатны сонгуульд ажиглалт хийхэд СтХ-иар тодорхойлж, эрх-үүрэг-хариуцлага болон бүртгэлтэй холбоотой асуудлыг нарийвчлан заасан учир ажиглалт хийхэд ноцтой хүндрэл, бэрхшээл тулгараагүй болно.

Ийнхүү хуульд заасны дагуу “Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээнээс 50 хэсэгт зохион байгуулсан ажиглалтын үйл ажиллагаанд бэлтгэгдсэн

ажиглагчид өглөөний 07:00 цагаас өмнө тус тусын хэсэгдод очиж ажиглалтаа эхлүүлж, санал хураалтын дүн гарч, техникийн тооллогын үйл явцыг бүхэлд нь ажиглаж чадсан.

Ажиглалтын үйл ажиллагааг сонгуулийн төв байгууллагаас дэмжиж, хамтран ажилласан. Хэдий тийм боловч анхан шатны нэгж буюу сонгуулийн хэсгийн ажилтнуудын хуулийн талаарх мэдлэг сул байсан нь зарим хүндрэлийг учруулж байсан. Тухайлбал, ажиглагчдыг бүртгэхээс татгалзах, бүртгүүлэхээр очсон ажиглагчидтай таагүй харьцах буюу “Дүүргээс хариу хүлээнэ,” “Нэг л ажиглагчийг бүтэн өдөр ажиллуул” гэх зэргээр хандаж байсан. Үүний улмаас ажиглагчаар бүртгүүлэх үйл явцад төв байгууллагад буюу СЕХ-той холбогдож, тэднээр дүүргийн хороо руу яриулах, дүүргээс хэсгийн хорооны ажилтнуудтай яриулж тайлбарлуулснаар ажиглагчийг бүртгүүлэх тохиолдлууд цөөнгүй гарсан.

Мөн сонгуулийн үеэр ТББ-ын ажиглагчийн эрх зүйн байдлыг үл хайхран намын ажиглагчдыг илүүд үзэх хандлагууд гарч байсан нь сонгуулийн хороод хуулийн хэрэгжилтийг хангах мэдлэг мэдээлэл дутмаг байсан гэж дүгнэж байна.

Техникийн тооллого хийх хэсгүүдийг сонгохдоо санамсаргүй хэлбэрээр сонгох үйл явцыг Дүүргийн сонгуулийн хороод сугалаа хэлбэрээр зохион байгуулахаар болсон боловч хаана, хэзээ, хэдэн цагт зохион байгуулах гэж буйгаа албан ёсоор зарлаагүй юм. Иймд бид дүүрэг тус бүрт оролцох албан хүсэлтээ бичгээр гаргасан бөгөөд Хан-Уул дүүрэг үнэмлэхтэй ажиглагчаа оролцуул гэсэн шаардлагыг тавьсан бөгөөд бусад дүүргийн хувьд ТББ-ын төлөөлөл байхыг зөвшөөрсөн. Энэ нь СЕХ-ноос баталсан журамд ажиглагчаар “сонгогч” байж болно гэж хуулийн агуулгыг явцууруулсан холбоотой юм. Цаашид энэ журмын зохицуулалтанд сугалаа явуулах үйл явцын ил тод байдал, мэдээлэл түгээх асуудал, ТББ-ын хяналт тавих асуудлыг тодорхой тусгах шаардлагатай байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний ажиглагчдын 6 дүүрэгт хийсэн 6-р сарын 26-ны 50 хэсгийн, 7-р сарын 7-ны 20 хэсгийн ажиглалт явуулсан мэдээллийг үндэслэн тус хэсгүүдийн хүрээнд 2017 оны Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн санал авах, санал тоолох, санал хураалтын дүнг гаргах ажиллагаа хуулийн дагуу явагдсан ба сонгуулийн дүнд нөлөөлөхүйц ноцтой зөрчил гараагүй гэж дүгнэж байна. Ажиглалт хийсэн хэсэгд дээр зохион байгуулалтын болон тохиолдлын чанартай зөрчлүүд гарсан ч энэ нь санал тооллогын дүнд сөрөг нөлөө үзүүлээгүй байна.

Сонгуулийн санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явцад гарсан зарим зөрчил, алдааг дурдвал:

Сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой дүгнэлт

Хуульд заасан журмын дагуу санал авах ажиллагааг явуулах үед сонгогчийн саналын нууцлал алдагдаж болохуйц нөхцөл байдал үүсч байсан нь сонгуулийн үндсэн зарчмын нэг болох сонгогч саналаа нууцаар гаргах зарчим алдагдуулсан байна. Мөн ХБ-тэй болон өндөр настан иргэдийн бусдын туслалцаатайгаар санал өгөх сонгуулийн эрхийн талаар СтХ-ын 91.11-т “Бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болох ба сонгуулийн байгууллагын ажилтан, албан тушаалтан, ажиглагч нь итгэмжлэгдсэн хүн байж болохгүй.” гэснээс өөрөөр тодорхой хуульчлаагүй нь иргэдийн саналаа нууцаар өгөх эрхийг зөрчигдөхөөс хамгаалж чадахгүй байна.

Ажиглагчдыг бүртгүүлэхтэй холбоотой, Сонгуулийн тухай хуулийн 107-р зүйлд заагдаагүй бичиг баримт нэхэх, нэмэлт тодорхойлолт шаардах, хоёр ажиглагч ээлжээр сэлгэн суухыг хориглох, танхимын багтаамж бага тул хагас өдрөөр бусад намын ажиглагчидтай ээлжлэх хэрэгтэй зэрэг хуульд заагаагүй шаардлагуудыг тавьж, бидний ажилд хүндрэл учруулж байсан нь сонгуулийн хуулийн холбогдох заалтын зорилгыг зөрчсөн гэж дүгнэж байна.

СЕХ-ны 2016 оны 6-р сарын 21-ний 172 дугаар тогтоолоор батласан “Техникийн тооллого хийх журам”-ын 1.3-т “Техникийн тооллого хийгдэх санал авах байрыг сонгох болон техникийн тооллого хийх ажиллагаанд сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн ажиглагчдыг оролцуулна. Гадаадын ажиглагчид, **сонгогчид**, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг ажиглагчаар оролцуулж болно” гэж заасан. Энэ нь үйл явцад зөвхөн гадаадын ажиглагч байна гэсэн нь СтХ-ийн 5 дугаар зүйлд заасан ил тод байх, ТББ-ын ажиглагч нь хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих эрхтэй гэсэн заалтыг явцууруулсан байна. Иймд энэхүү үйл явцад ТББ-ын ажиглагч нь “сонгогч”-ийн төлөөлөл гэсэн утгаар оролцох хүсэлтийг дүүргийн сонгуулийн хороонд тавихаас өөр аргагүй болсон.

Сонгуулийг зохион байгуулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн саналаа өгөх нөхцөл байдал хангагдаагүй. Сонгуулийн хэсгүүдийн зохион байгуулалт улмаас болон санал авах ажиллагааны явцад сонгогчийн саналын хуудсан дах саналын нууцлал алдагдахуйц нөхцөл байдал үүссэн, мөн зарим мэдээллийг ажиглагчдад зарлаагүй бөгөөд бичиг баримттай танилцах боломжоор хангаагүй, журамд заасан ажиллагааг ажиглагчдын ажиглалтаас гадуур хийх, дотоодын байгууллагын ажиглагчдад ялгавартай хандаж ажиглалт хийх нөхцөл боломжоор бүрэн хангахгүй байх, санал тоолох ажиллагаа явуулах дараалал, хийгдвэл зохих ажиллагааны талаар сонгуулийн хэсгийн дарга, гишүүд зохих мэдлэггүй байх, түүний улмаас зарим ажиллагааг орхигдуулах, ажиглагчдыг мэдээлэлтэй танилцах боломжоор хангахгүй байх, санал тоолох ажиллагааны үед утсаар ярих зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Сонгогчдын боловсролтой холбоотой дүгнэлт

Ажиглагчдын мэдээллээс үзвэл сонгогчид саналын хуудсан хэрхэн тэмдэглэгээ хийх, саналын хуудсаа төхөөрөмжид хэрхэн уншуулах талаар хангалттай мэдээлэлгүй байсан байна. Мөн өөрийнхөө нэрийг нэрийн жагсаалтад байгаа эсэхийг нягтлаагүй, хуульд заасан бичиг баримттайгаар санал авах байранд ирэхгүй байсан нь сонгогч өөртөө хүндрэл учруулахад хүрч байсан. Түүнчлэн саналын хуудасныхаа тэмдэглэгээг бусдад харуулах, саналын хуудасны зураг авах, бусад иргэний саналын хуудсыг төхөөрөмжид уншуулах зэрэг хуульд заасан зөрчлүүдийг гаргасан байна. Үүнээс гадна “хэнийг ч дэмжээгүй санал” буюу нэг ч нэр дэвшигчийг сонгохгүй байх эрхийн талаар мэдээлэл хангалтгүй байснаас бүгдийг нь дугуйлах, саналын хуудсаа урах зэрэг үйлдүүд гаргасан байна.

Сонгуулийн автоматжуулах иж бүрдэлтэй холбоотой дүгнэлт

Сонгуулийн автоматжуулсан системийн ажиллагаа нь тогтвортой байсан бөгөөд зарим тохиолдолд төхөөрөмжийн толгой бохирдох болон цаасны бөөгнөрөлийн улмаас гацсан боловч тухай бүрт нь зассан байна.

Сонгуулийн саналыг тоолох дүн гаргахтай холбоотой дүгнэлт

Санал хураалтын дүнг төв серверт дамжуулж, нэгтгэгдэж буй дүн телевизээр шууд цацагдсан бөгөөд иргэд сонгогчдод сонгуулийн дүн нээлттэй, шуурхай хүрч байсан.

Зөвлөмж

Ажиглалтын үр дүнгээс үүдэн Сонгуулийн тухай хууль тогтоомж болон сонгуулийн үйл явцыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжүүдийг гаргаж байна.

Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой зөвлөмж

- Сонгогч өөрийн итгэмжлэгдсэн хүний туслалцаа авах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хяналт хийх ТББ-үүдын онцлогийг харгалзан, оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч нэг хэсэгт ажиллах ажиглагчийн нэг байгууллагаас нэг ажиглагч гэж хязгаарлахгүй байхаар тогтоох;

Сонгуулийг зохион байгуулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж

- Сонгуулийн хэсгийн гишүүдийг хууль тогтоомжийн хэрэгжүүлэлтийн талаарх нэгдсэн ойлголттой болгох сургалтын чанарыг сайжруулах, мэдээллээр бүрэн хангах дээр анхааран ажиллах;
- Дотоодын байгууллагын ажиглагчдын статус, тэдгээрийн эрх үүргийн талаар дүүргийн болон хэсэгны гишүүдэд таниулах, ийнхүү ажиглагчдад хуулиар олгогдсон эрх үүргийн хүрээнд бичиг баримттай танилцах, мэдээлэл авах бодит боломжоор хангахад анхаарах;

- Хэсгийн сонгуулийн санал авах, санал тоолох, санал хураалтын дүн гаргах бүхий л ажиллагааны үед холбогдох ажиллагаа болон бичиг баримтыг ажиглагчдын нүдэн дээр хийх, холбогдох баримтанд ажиглагчдыг танилцуулж гарын үсэг зурлуулах боломж, оролцоогоор хангах;
- Хэсгийн дарга, гишүүд, мэдээллийн технологийн даамал нь сонгогчид ямар нэгэн байдлаар нөлөөлөх, саналын хуудастай танилцах, сонгогчийн өмнөөс саналын хуудсанд тэмдэглэгээ хийх, заавал аль нэг нэр дэвшигчийг сонгох ёстой гэж шаардах явдлыг таслан зогсоох;

Сонгогчдын боловсролтой холбоотой зөвлөмж

- Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, тухайлбал, саналын хуудсанд хэрхэн тэмдэглэгээ хийх, санал тоолох төхөөрөмжид хэрхэн саналын хуудсаа уншуулах болон сонгогчдод шаардлагатай мэдээллийг нээлттэй, ойлгомжтой хэлбэрээр цаг алдалгүй хүргэх дээр анхааран ажиллах;
- Сонгогчдод санал авах ажиллагааны үед хориглосон зөрчлийн талаарх мэдлэг ойлголтыг олгох, зөрчсөн тохиолдолд таслан зогсоох арга хэмжээ авах;

Сонгуулийн санал авах байр болон автоматжуулах иж бүрдэлтэй холбоотой зөвлөмж

- Санал авах байрыг бэлтгэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэн саналаа хүндрэлгүй өгөх нөхцөл бололцоог хангасан налуу шат, санал бэлтгэх бүхээг, томруулдаг шил зэргийг нийт хэсэгд бүрэн бэлтгэсэн байхад анхаарах; Харааны бэрхшээлтэй сонгогчдод зориулсан баррел үсэгтэй саналын хуудас хүртээмжтэй бэлтгэх; Мөн санал авах байрыг тухайн барилгын 2, 3, 4 давхарт байгуулахаас зайлсхийх;
- Иргэний бүртгэлийн сүлжээ, санал тоолох төхөөрөмжийн иж бүрдлийн хэвийн ажиллагааг хангах, дүнг төв серверт дамжуулах үед сүлжээний ачааллыг тохируулах арга хэмжээ авдаг байх;